

**УЛС ТӨР**

**БҮГД НАЙРАМДАХ УЛСАА  
ТУНХАГЛАСНЫ БАЯРЫН ӨДРӨӨ  
ТЭМДЭГЛЭЖ БАЙХААР БОЛЛОО**

II нүүрт

**ОНИЦЛОХ ХУУДАС**

**БИЧИН ЖИЛИЙН ӨВӨЛ БЯД  
ШАЛГАЖ ЭХЭЛЛЭЭ**

V нүүрт

**ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА**



Гэрэл зургийг Д.ДӨЛГӨН

Дугаарын **60** мөр

Төрийн музей үнэгүй  
бие засах газар биш

ЖОТГОН

Эзэн Чингис хааны хөшөө цогцолборын өмнүүр татдаг улаан туузыг Шинэчлэлийн Засгийн газрын тэргүүн сайд нарынхаа хамт 2012 оны наймдугаар сарын 26-ны өдөр хайчилж байсан. Ингэснээр иргэд Чингис хааны хөшөө, наадмаар л барааг нь хардаг байсан Есөн холт цагаан тугандаа хүндэтгэл үзүүлж, дэргэд нь зургаа татуулах боломжтой болсон. Монгол төрийн түүхийн музейд 2000 гаруй биет үзмэрийг байрлуулсан бөгөөд манай улсад бүртгэгдсэн түүх, соёлын хосгүй үнэт 612 дурсгалын 289 нь сан хөмрөгт нь багтсан байдаг. Тухайлбал, Монгол түмний төрийнхөө ёслолд хэрэглэж байсан сүлд, туг, далбаа, тамга, дууллыг энд хүндэтгэлтэйгээр залж, Хубилай хааны зарлигаар 1270 оны орчим бүтээсэн "Арван буянт номын цагаан түүх" зохиолд дурдсан Хаан төрийн есөн их бэлгэ, Богд Живзундамба хааны зарлигаар 1915 онд бичигдсэн "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичиг"-т заасан Олноо өргөгдсөн Монгол Улсын төрийн долоон эрдэнэ бий.

Үргэлжлэл нь III нүүрт

**ҮЗЭЛ БОДОЛ**

## МОНГОЛООС "ДҮРВЭГСЭД" - ИЙН ОРОГНОХ ГАЗАР ЭЛЧИН САЙДЫН ЯАМД БОЛОВ УУ

**Н.ПУНЦАГБОЛД**

Засаг төр солигдсоноос хойш хийгдэж буй халаа сэлгээ, томилгоо одоог хүртэл дуусаагүй л байна. Өнгөрсөн дөрвөн жилд Монголоос хол байсан нөхдүүд эргэж ирж, даргын суудалд сууцгаагаад л. Сошиал ертөнцөөр Монголын хүйтэн, их цас орж байгааг гайхах нь нэн сонин. Халуун оронд, утаагүй газар дөрвөн жил уушгиа цэвэрлэхэд ирсэн болохоор Улаанбаатарын их утаанд амьсгал нь давчдаж, хэд хоногийн цасанд хөл гар нь бэрч, суусан зөөлөн сандлаа бодож хатуу бэрхийг тэвчигсэд Монголоор л дүүрэн байгаа бололтой. Үүний хажуугаар Монголд байж тэсэхгүй, утаанд уушги нь дасаж өгөхгүйн хажуугаар дипломат нэрээр гадаад руу дүрвэгсэд томилгодож эхэллээ. Зарим нь Улаанбаатарын утааг

тэсэн байж зөөж хураасан хэдээ аваад гадагшаа явдаг ч байж магадгүй.

Ямартаа ч өнгөрсөн долоо хоногт Засгийн газраас нэр бүхий 10 хүнийг Элчин сайдаар томилж УИХ-аар оруулж, дэмжүүлээ. Дэмжүүлэх ч юу байх вэ дээ, нэгэнт хийчихсэн тохироо, шийдчихсэн шийдвэрээ парламентад сууж байгаа нүдэн балай кнопчид шинэковуудаараа гар өргөн дэмжүүлэх үйл ажиллагааг хийв. Элчин сайдаар явж, гадны сайхан орнуудад бүрэн эрхтэй тарвалзах хүмүүсийн дунд Ерөнхий сайд асан С.Баяр, М.Энхсайхан тэргүүтнүүд багтсан нь олон хүний уур ундууцыг төрүүлсэн төдийгүй парламентад суугаа эрхбиш үгээ хэлчихдэг ганц нэг хүн шүүмжлэв.

Үргэлжлэл нь III нүүрт

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**

Өдөр -31  
Шөнө -21

**ДЭЛХИЙ**

## АНУ-ЫН 45 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ Д.ТРАМПЫН КАБИНЕТ ЯМАР БАЙХ ВЭ



**TRUMP  
PENCE**

**Б.ДАВАА**

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль энэ сарын 8-нд явагдаж, бүгд найрамдах намаас нэр дэвшсэн үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулж, тус улсын 45 дахь төрийн тэргүүнээр тодорсон билээ. Одоогийн Ерөнхийлөгч Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа ирэх оны нэгдүгээр сард дуусч, Доналд Трамп мөн сарын 20-нд тангарагаа өргөх юм. Улмаар тангараг өргөснийхөө дараа өөрийн багаа бүрдүүлэн, улс төрийн томилгоогоо хийх учиртай. Тэгвэл одооноос үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эр өөрийн кабинетээ бүрдүүлж эхэлсэн төдийгүй, түүний багийн чухал чухал албан тушаалд томилгодох эрхмүүдийн нэрс эхнээсээ тодорч эхлээд байна. Ингэхдээ Д.Трампын баримталж буй байр суурь нь тун өвөрмөц байх бөгөөд багтаа өөрийг нь дэмжигчдийг илүүтэй нэгтгэсэн нь олны анхаарлыг татаад байгаа юм. Ингээд Трампын кабинетыг сонирхуулж байна.

Үргэлжлэл нь VI нүүрт



Энэтхэгийн Элчин сайдын яам  
Улаанбаатар

## ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

2016-11-16-нд Энэтхэгийн Элчин сайд Д-р Т. Суреш Бабу Монгол улсын Их хурлын дарга, Эрхэмсэг ноён М.Энхболдод бараалхлаа. Хоёр талдаа тааламжтай цагт Монголын Парламентын төлөөлөгчдийг тэргүүлэн Энэтхэг улсад айлчлахыг урьсан Энэтхэгийн Парламентын доод танхим Лок Сабхагийн дарга, Эрхэмсэг хатагтай Сумитра Махажаны албан урилыг Элчин сайд М. Энхболд даргад гардууллаа.

Уулзалтын үеэр нэг тэрбум ам. долларын зөөлөн кредитын ач холбогдол, уг зээлийг Монголын янз бүрийн төсөл хөтөлбөрт аль болох хурдан хэрэглэх нь чухал болохыг Элчин сайд, Монголын удирдагч өндөр үнэмлээ. Батлан хамгаалах, хил, соёл, боловсролын салбар дахь Энэтхэг, Монголын харилцааг Монгол Улсын Их хурлын дарга өндөр үнэмлээ. Улаанбаатар, Делийн хооронд шууд нислэгээр холбогдохын чухлыг хоёр тал цохон тэмдэглэж, ийм харилцаа ойрын үед хэрэгжинэ хэмээн итгэж байгаагаа илэрхийлэв. Улаанбаатарын Энэтхэг-Монголын Найрамдалын Сургууль ба Мэдээлэл, Холбооны Технологийн Төв зэрэг бусад төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хурдачлахаар харилцан тохиров.

2016-11-18.



**БИД ТАНЫ АЖЛЫГ ХҮНДЭЛНЭ**



Алдаж болохгүй алтан боломж

Dell –ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аварай.



**ХААН Банк**

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2418.00	2442.00	ФУНТ	2950.00
ЕВРО	2533.00	2613.00	РУБЛЬ	35.80
ИЕН	21.98	22.26	ЮАНЬ	349.00

**Хугалгаа хөгжлийн банк**

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2420.00	2446.00	ФУНТ	2953.00
ЕВРО	2523.00	2660.00	РУБЛЬ	35.02
ИЕН	21.49	22.70	ЮАНЬ	349.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

## УЛС ТӨР

## МЭДЭЭЛЭЛ

## Ж.Бямбадорж: Иргэдийн хөдөлмөрлөх эрхийн асуудалд анхаарч ажиллана

УИХ-ын дарга М.Энхболдод Хүний эрхийн үндэсний комиссын даргаар улираан томилогдсон Ж.Бямбадорж бараалхлаа. Уулзалтын эхэнд Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж итгэл найдвар хүлээлгэн нэр дэвшүүлж, улираан томилогдсон талархал илэрхийлээд тус комиссын дарга томилогдсон даруйдаа Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын даргад бараалхдаг журамтайг дурдав.

Тэрбээр “Өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн үндэсний комисс багагүй ажлыг хийж, дотооддоо төдийгүй Ази, Номхон далайн бүсийн хэмжээнд нэр хүндээ өсгөж чадсан. Ирэх жилүүдэд иргэдийн хөдөлмөрлөх эрхийн асуудалд түлхүү анхаарал хандуулж ажиллахаар төлөвлөж байна. Нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотойгоор 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайшгүй цаг үеийн шаардлага үүсч байна. УИХ-ын зүгээс анхаарал хандуулахыг хүсье” хэмээн хэлсэн үгэндээ тэмдэглэв. УИХ-ын дарга М.Энхболд Хүний эрхийн үндэсний комиссын даргаар улираан томилогдсон нь Ж.Бямбадоржид баяр хүргээд Монгол Улсын Хүний эрхийн байгууллагын нэр хүндийг өсгөсөн байдал, ажлын дадлага, туршлага зэрэг олон хүчин зүйлийг үндэслэн нэр дэвшүүлж, улираан томилогдсон гэдгийг онцоллоо.

## ЧУУЛГАНЫ ТАНХИМААС



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## БҮГД НАЙРАМДАХ УЛСАА ТУНХАГЛАСНЫ БАЯРЫН ӨДРӨӨ ТЭМДЭГЛЭЖ БАЙХААР БОЛЛОО

Ж.ОПТОН

УИХ-ын өнгөрсөн баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, гишүүдийн 83.7 хувийн саналаар төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталлаа. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийг хэлэлцэх шатанд УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах санал гаргасан юм. Уг хууль батлагдсанаар жил бүрийн арваннэгдүгээр сарын 26-нийг Бүгд найрамдах улсаа тунхагласны баярын өдөр болгон тэмдэглэж байхаар болж байна.

Төсөл санаачлагч гишүүд 1924 оны арваннэгдүгээр сарын 26-ны энэ өдөр Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, хаант засгаас Бүгд найрамдах засаглалд шилжиж, хамжлагат ёсыг халсан Монголын түүхийн томоохон үйл явдал тохиосон учир энэ өдрийг нийтээр тэмдэглэх баярын өдөр болгох нь зүйтэй хэмээн үзэж энэхүү хуулийн төслийг санаачлан боловсруулжээ. Учир нь 1924 оны арваннэгдүгээр сарын 26-нд Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, хаант засгаас Бүгд найрамдах засаглалд шилжиж, хамжлагат ёсыг халан үндэсний ардчилсан өөрчлөлт, эрх зүйн чухал зарчмууд, улс төрийн цоо шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулсан нь Монголын түүхийн асар том үйл явдал болсон билээ. Тиймээс жил бүрийн арваннэгдүгээр сарын 26 буюу Үндсэн хуульд Бүгд найрамдах улсаа тунхагласны өдрийг манай улс нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон тэмдэглэдэг байв. Харин 2012 оноос уг өдрийг тэмдэглэлт өдрийн төвшинд тэмдэглэн өнгөрөөх болсон нь түүхийн чухал үйл явдлын ач холбогдлыг багасгаж, түүх уламжлалыг бүдгэрүүлэх алдаатай шийдвэр болсон талаар ард иргэд шүүмжилж, эрдэмтэн мэргэд байр сууриа илэрхийлдэг тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж энэ өдрийг нийтээр

тэмдэглэх баярын өдөр болгох нь зүйтэй гэж төсөл санаачлагчид үзсэн байна.

Ж.Батзандан: Санхүүгийн зохицуулах хороо Монголбанкны дагавараар хүүхэд шиг ажилладаг

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн дараагийн асуудал нь Санхүүгийн зохицуулах хорооны гишүүдийг томилж, чөлөөлөх асуудал байлаа. Үүнд, О.Батбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр томилохыг гишүүдийн 88.2 хувийн саналаар, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Б.Баярдалайг томилохыг гишүүдийн 86.5 хувийн саналаар, Л.Энхтайвныг орон тооны бус гишүүнээр улираан томилохыг 81.5 хувийн саналаар, Б.Батхшигийг орон тооны бус гишүүнээр томилохыг 84.6 хувийн саналаар тус, тус дэмжин баталлаа. Томилгоог батлахын өмнө УИХ-ын гишүүн Ж.Батзандан: “Засгийн газар өөрчлөгдөхөөр хамгийн түрүүнд банк, санхүүгийн байгууллагад холбогдох төрийн байгууллагын бүтэц рүүгээ довтолдог. Өмнө томилогдсон гишүүдийнх нь бүрэн эрхийн хугацаа дуусаад томилж байгаа л гэж найдлаа. Санхүүгийн зохицуулах хороо амар ажил биш. Монгол Улсын санхүү эдийн засгийн бодлогыг тодорхойлдог, байнгын дарамт шахалтад байдаг байгууллага. Та нар дарамтлуулах гэж очиж байгаа шүү гэдгээ сайн ойлгоорой. Эдийн засгийн нөхцөл байдал маш хүнд байгаа. Банк бус санхүүгийн байгууллага танайд харьяалагддаг. Ломбардыг Монголбанк ч, Санхүүгийн зохицуулах хороо ч хяналтдаа авч чадаагүй. Хууль эрх зүйн орчноо тодорхой болгож, тодорхой хувийг хяналтдаа ав. Өнөөдрийг хүртэл ойлгомжгүй явлаа. Санхүүгийн зохицуулах хороо өөрөө санаачилгатай байхгүй бол Монголбанкны дагавараар хүүхэд шиг ажилладаг. Эрлийз саармаг, юу хийх гээд байгаа нь тодорхойгүй

харагддаг. Өнгөрсөн парламентын үед үнэт цаасны тухай хуулийг баталсан. Хуулиа амьдралдаа хэрэгжүүл. Газрын бирж байгуула, уул уурхайн бирж ажиллуула гэсэн байхгүй. Шинээр томилогдож байгаа 2-3 гишүүн байна санаачилгатай ажиллаарай” гэлээ. Харин УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Тэрбишдагва: Санхүүгийн зохицуулах хорооны нэг ч гишүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлсөн юм байхгүй” гэдгийн онцолж байлаа. Мөн хуралдаанаар бүрэн эрхийн хугацаа нь дууссантай холбогдуулж, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээс Х.Бум-Эрдэнэ, Д.Ганбаяр, Д.Ганбат нарыг чөлөөллөө.

Ж.Эрдэнэбат: 32.3 мянган га талбайн ургац алдсан

УИХ-ын чуулганы үдээс хойших хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат ургац хураалтын дүн мэдээ, мал аж ахуйн салбарын өвөлжилтийн талаар мэдээлэл хийлээ. 2016 оны ургац хураалтын урьдчилсан дүнгээр нийтдээ 475.8 мянган тонн үр тариа, үүнээс 460.7 мянган тонн буудай, 153.7 мянган тонн төмс, 93.5 мянган тонн хүнсний ногоо, 19.6 мянган тонн тосны ургамал, 50.6 мянган тонн тэжээлийн ургамал буюу нэгжээс 14.0 цн улаанбуудай, 105.0 цн төмс, 112.1 цн хүнсний ногоо, 17.3 цн тэжээлийн ургамал, 3.1 цн тосны ургамал тус тус хураан авчээ. Аж ахуйн нэгж, иргэд 388.9 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэсний 108.1 мянган га талбайг нь дэвшилтэт технологиор боловсруулсны зэрэгцээ дараа оны тариалалтад зориулан 45.5 мянган тонн үр нөөцөлсөн байна. Энэ жилийн хувьд Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг бүхэлдээ Төв аймгийн зарим бүс нутагт хур тунадас багатай, гандуу байснаас ургац алдаж, нэгжээс дунджаар 3.6-8.0 цн ургац хураан авсан байна. Бусад бүс нутагт цаг агаар харьцангуй тааламжтай байснаар ургацаа амжилттай хураах нөхцөл бүрдсэн боловч 9-10 дугаар сард нийт нутгаар хур тунадас ихтэй, талбайд

техник ажиллах боломж хомс байсан нь ургац хураалтад хүндрэл учруулан, ургацын хаягдлыг нэмэгдүүлж, хураан авах ургацын хэмжээнд сөргөөр нөлөөлжээ. Байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр 31.3 мянган га талбайн ургац ганд нэрвэгдэж, болц дутуу хэмжээнд 1.0 мянган га талбай тэжээлд шилжсэнээр нийтдээ 32.3 мянган га талбайн ургац алджээ. Хураан авсан ургацын динамик тоо мэдээллээс авч үзвэл, манай газар тариаланчид сүүлийн 25 жилд гурван удаа 460.0-аас дээш мянган тонн буудай хураан аваад байна. Тухайлбал, 2012 онд 461.8 мян тн, 2014 онд 489.4 мян тн, 2016 онд 460.8 мян тн тус тус хураан авсан. Энэ нь Монгол Улсын Засгийн газраас газар тариалангийн салбарыг тогтвортой хөгжүүлэх талаар удаа дараагийн зөв зүйтэй арга хэмжээ авч ирсэн, “Атрын Ш яан” хөтөлбөр хэрэгжүүлсний нааштай үр дүн гэж үзэж болох аж. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах хүрээнд Засгийн газрын 322 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан даалгаврыг батлан гаргаж хэрэгжүүлж байгаа аж. Энэ хүрээнд аймгуудын Засаг даргын захирамж, аймгийн Онцгой комиссын даргын захирамж, бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа. Улсын хэмжээнд нийт 153.1 мянган малчин өрхөд 60.8 сая, хонин толгойд шилжүүлсэнээр 100.4 сая толгой малыг өвөлжүүлэх бэлтгэл ажил, зохион байгуулалт хийжээ. Өвөл хаврын бэлтгэлийн даацын судалгаагаар нийт нутгийн 80.0 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 20.0 хувь нь хүрэлцээ муутай байгаа тул отроор өвөлжих өрх, малын тооны талаар аймаг, сумдын удирдлагууд харилцан тохиролцон гэрээ байгуулж байна. Үүний үр дүнд нийт 16.5 мянган өрхийн 6.9 сая мал отроор өвөлжиж, хаваржихаар зохион байгуулалт хийгджээ.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, харилцан авснаар өнгөрсөн баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлсэн юм.



### МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:

С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч:

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ  
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Э.ЭНХЦЭЦЭГ  
88873012

Ахлах редактор:

Б.ӨНӨРТОГТОХ  
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба

Н.ПУНЦАГБОЛД  
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:

Б.ӨНӨРТОГТОХ  
88006842

Гэрэл зургийн алба:

Г.АРГУУЖИН  
96017873

Компьютерийн алба:

Б.ГАНЗОРИГ  
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:

Н.АЛТАНЦЭЦЭГ  
99173710

Захиалга, борлуулалтын алба:

М.ДАВААДУЛАМ  
99042510Э.САЙНЗАЯА  
99197866

Дугаарыг эрхэлсэн

Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528

Индекс: 100757

Редакцийн хаяг:

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцияд эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.



## Гар ажиллагаанд гаршигч Су.БАТБОЛД

Улаанбаатар хотод цаснаасаа салсан нэг ч зам алга. Учир нь өнөөх цасыг цэвэрлэх нөхдүүд “мөнгө байхгүй” гэх шалтгаанаар шүүрээр шүүрдээд л байгаа гэх. Гэтэл хотын дарга халтиргаа гулгаатай унаж гэмтээд, осолдож, мөргөлдөөд үгээ хэлж байгаа иргэдийнхээ уурыг улам ч хүргэсэн үйлдэл хийгээд авлаа. Тэрбээр өнгөрсөн амралтын өдөр нийт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг бүх нийтийн цас цэвэрлэгээнд уриалсан.

Улмаар өөрөө хүрж байриад цас цэвэрлэж байгаа зургаа хийж “шоудсан” нь түүнийг сайхан харагдуулах бус харин ч гутаасан үйлдэл боллоо. Уг нь тэр хүнийг сайн менежмент хийж хотоо удирдаад өгөөч гэж сонгосон болохоос хүрз бариад гудамжны цас цэвэрлээд өг гэж сонгоогүй гэдгийг тэрбээр мэдэхгүй байгаа бололтой. Уг ард иргэдээ гараар нь цас ухуулаад зогсох бус техник технологи хөгжихсэн өнөө үед ямар ч шийдвэр хурдан хугацаанд цаснаасаа салах бүрэн боломж баймаарсан.



Тэгвэл яагаад сүүлийн үеийн ажлын өндөр бүтээмжтэй техник хэрэгсэл авахгүй цастай “улаан гараараа үзэлцээд” байгаа талаар нийслэлийн Засаг Дарга Су.Батболдоос тодруулахад “Өнгөрсөн жилүүдэд хамаг мөнгийг хогны уутанд зарцуулчихсан. Одоо мөнгө байхгүй” гэсэн тайлбар өгч байгаа сурагтай.

Түүнчлэн өмнөх хотын даргатай түүний хийсэн ажлыг харьцуулаад байгаа иргэдэд “Өнгөрсөн жилд бүтэн өвлийн турш 13 удаа цас орсон. Харин энэ жил өвөл эхлээд л буюу ганцхан сарын дотор 13 удаа цас орсон” хэмээн “гоншигнож” байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, Су.Батболдод хурмаст тэнгэр хүртэл хатуу хандаад байгаа юм байх, хөөрхий.

## Н.Учрал тэргүүтэй парламентын гишүүд ОХУ-д ажиллаж байна

УИХ-ын гишүүн Н.Учрал, Г.Тэмүүлэн, Н.Цэрэнбат нар ОХУ-д албан томилолтоор ажиллаж байна. Монголын парламентын гишүүд энэ үеэр ОХУ-ын Холбооны Төрийн думын зарим гишүүдтэй уулзаж, санал солилцжээ. УИХ-ын гишүүн Н.Учрал уулзалтын эхэнд ОХУ-ын Төрийн думын гишүүн Сергей Железняк, Төрийн дум дахь ОХУ-Европын парламентын бүлгийн дарга Андрей Климов нартай уулзаж буйдаа баяртай байгаагаа илэрхийлээд Монгол, ОХУ хоорондын олон уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэхэд парламент хоорондын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг онцоллоо. Мөн тэрбээр нийслэл хотын тойргоос сонгогдсон гишүүний хувьд Москва хоттой боловсрол солилцооны тал дээр хамтран ажиллах санал гаргасан бөгөөд талууд бүхий л зүйл дээр хамтран ажиллахаар тохирсон байна.

## Засгийн газартай Далай ламын айлчлал холбоогүй гэв

Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчинлэн хийд, Монголын сүм хийдүүд, сүсэгтэн олны урилгаар Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам өнгөрсөн баасан гарагт Улаанбаатар хотод ирсэн. Түүний энэхүү айлчлалыг Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчинлэн хийдийнхэн цэвэр номын айлчлал хэмээн мэдэгдсэн. Харин БНХАУ-ын Гадаад харилцааны яамнаас “Монгол Улсад айлчлал ирсэн Буддын шашны тэргүүн Дээрхийн гэгээнтэн XIV Далай ламыг Монгол Улс хүлээж авахгүй байх ёстой” хэмээн мэдэгдэл хийсэн юм. Тэгвэл үүний хариу тайлбар болгож, “Дээрхийн гэгээнтэн XIV Далай ламын Монголд хийж байгаа айлчлал Монгол Улсын Засгийн газартай холбоогүй” гэсэн мэдэгдлийг өнгөрсөн баасан гарагт Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил хийлээ.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

## Төрийн музей үнэгүй бие засах газар биш

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Түүнчлэн Эзэн Чингис хааны нутгийн хөрс шороо, рашааны дээжүүд, Чингис хаан, түүний дөрвөн хөвүүний удмынхны бүтээн дээдэлж ирсэн Хаадын овгийн тамганууд зэрэг бидний төрөө дээдлэн шүтэх олон зуун жилийн өв уламжлалыг шингээсэн бэлгэдлийн эд зүйлсийг байрлуулсан байгаа.

Хэдийгээр Төрийн ордон түмэн олондоо хаалгаа нээж, төрт ёсны 2000 гаруй жилийн бахдам түүхээрээ бахархах, омогших боломжийг иргэн бүртээ олгож байгаа нь нэг талдаа сайн хэрэг. Өөрөөр хэлбэл, хэнд ч үзүүлэхгүй, харуулахгүй доожтой хаалганы цаана байлгаж байснаас иргэддээ үзүүлж, харуулж байгаа нь авууштай. Гэвч нөгөө талдаа болохгүй, бүтэхгүй зүйл олон байна. Учир нь сүүлийн үед төрийн түүхийн музей гэдэг газар болзоондоо ирэхгүй, удах нэгнээ хүлээх зуураа толгой хоргодох дулаан газар, төв талбайд дахь үнэ төлбөргүй бие засах газар болон хувираад байгаад шүүмжлэгтэй хандах иргэд цөөнгүй байна. Ялангуяа энэ байдалд сэтгэл дундуур байгаа ахмад буурлууд олон байгаа юм.

Гэхдээ хүн бүр үл хүндэтгэж байна хэмээн харуулах гэсэнгүй. Төрийн ордны босгоор анх удаагаа алхаж байгаа, Их эзэн хааныхаа хөшөөнд сүслэж, Монгол төрийн түүхэн уламжлал бахархлын бэлэг тэмдэг болсон үзмэрүүдтэй танилцаж байгаа хүн олон байгаа. Бүр Есон холт цагаан тугандаа сүсэглэн мөргөж байгаа иргэд цөөнгүй бий. Тиймээс нэгэнт нээсэн хаалгаа хаа гэсэн юм биш. Харин тодорхой хамжээний тариф тогтоож, хийх байх юм аа олж ядсан нэгэн Монгол төрийн түүхийн музейд орох бус. Харин зорин, зорин хөлс мөнгөө төлөөд үздэг болгох хэрэгтэй байна. Хэрвээ тодорхой хэмжээний мөнгө төлөөд үздэг болгочихвол дуртай нэг нь орж бие засаад гарахгүй. Ёстой үзэхийг хүссэн нэгэн нь төрт ёсныхоо түүхтэй танилцаад гарах нь дамжиггүй биз ээ.

...Нэг талаараа Монголоос “дүрвэгсэд” гээд хэлчихэд ч буруудах юмгүй байх.

Монгол төрийн алба харьсан бөх, тарсан хамтлагийн “орогнох” газар болж хувирчихаад байгаа. Түүнтэй адил Элчин сайд, дипломат алба гэдэг тохиролцооны хүнээ шахдаг, Монголд байх “эрхгүй”, бас сонирхолгүй болсон нөхдүүдийг орогнуулдаг газар болж байх шиг байна...

Бас л хоёр төрд нүүртэй хүн юм. Эсвэл хоёр намынхны судсыг “атгаж” чадсан хүн байж ч болох юм.Түүнийг гишүүн Х.Болорчулуун “Монголын үндэсний үйлдвэрлэл, аж ахуйн нэгжүүдийг дампууруулсан нөхөр” хэмээн улаан нүүрийг нь улаалтал хэлсэн.

Энэ мэтээр цөөнгүй хүмүүс Элчин сайдын суудлаар “шагнуулж” гадаад руу явлаа. Нэг талаараа Монголоос “дүрвэгсэд” гээд хэлчихэд ч буруудах юмгүй байх. Монгол төрийн алба харьсан бөх, тарсан хамтлагийн “орогнох” газар болж хувирчихаад байгаа. Түүнтэй адил Элчин сайд, дипломат алба гэдэг тохиролцооны хүнээ шахдаг, Монголд байх “эрхгүй”, бас сонирхолгүй болсон нөхдүүдийг орогнуулдаг газар болж байх шиг байна. Нэг ёсондоо дипломат алба дампуурч гүйцдээ гээд хэлчихвэл буруудсан болохгүй буй за. Уг нь дипломат алба гэдэг хамгийн чухал харилцаа, жинхэнэ мэргэжил шаардсан, хатуу шалгуур үзүүлэлтүүдтэй газар байдаг л юм гэнэ билээ. Улс төрийн тохироо, шагналын маягаар өгөхөд бол тэр хүний боловсролтой, чадалтай, тухайн улсад эх орноо зөвөөр сурталчилж, Монголынхоо иргэдийн эрх ашгийг хамгаалж чадах эсэх нь хэнд ч хамаагүй бололтой. Тэд л өөрсдөө сэтгэл ханамжийн баталгаа 100 хувь, сайхан инээмсэглэл тодруулаад Монголоос “дүрвэж” байвал болж байх шиг байна. Элчин сайдын суудлаа гэж. Зарим гишүүдийн хэлдгээр шагнал л болж дээ.



## МОНГОЛООС “ДҮРВЭГСЭД”-ИЙН ОРОГНОХ ГАЗАР ЭЛЧИН САЙДЫН ЯАМД БОЛОВ УУ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Хугацаа нь дуусаагүй Элчин сайдуудыг эргүүлэн татаж, оронд нь хүн явуулж буй нь ч “хэрүүллийн алим” болсон юм. Ерөөс Монголоос ямар нэг байдлаар “дүрвэх” сонирхолтой хүмүүсийг орогнуулах зорилготой томилгоо болчихлоо хэмээн хүмүүс ярьж байна. УИХ-ын гишүүдийн зарим нь ч ниймэрхүү байр суурьтай байж, зад шүүмжиллээ. Тэр дундаа Ерөнхий сайдаар ажиллаж байсан М.Энхсайхан, С.Баяр нар хатуу үг сонсов. Тэднийг улс орныхоо төлөө хэрэгтэй зүйл хийж чадах уу гэж асуух нэгэн байхад “бохь зажлаад, пээдгэр байна” гэж загнах нэг нь ч байлаа. Мөн ашиг сонирхлын зөрчилтэй, өөрийн эрх

ашгаа бодож явж байгаа юм биш биз гэж хардах гишүүн ч байсан. Гэвч С.Баяр тэднийг юман чинээ тоосонгүй, харин ч өөрийгөө Монгол Улсад том гавьяа байгуулсан учраас тэр гавьяаныхаа амралтыг эдэлж, Англид Элчингээр суух ёстой хүн мэтээр хандана лээ. С.Баяр бол МАН-ын том лидер, цагтаа Орост Элчин явлаа. Монгол Улсын Ерөнхий сайд ч байсан. Сая 2016 оны сонгуулиар Монголд оо ирж, намаа удирдсан. Түүний өмнө гадаадад амар сайхандаа жаргаж байсан. Сонгуулиар намаа ялагтад хүргэчихээд, нэг хэсэгтээ л үзэгдэхгүй байж байгаад саяхан ирээд, Элчин сайд болох “бэлэг”-ээ гардаж аваад л Их Британи руу томилгодов. Эртнээс л тохирсон байсан байж таарна. М.Энхсайханы хувьд өнгөрсөн дөрвөн

жилд эрх баригчдын судсыг атгаж, “Шийдлийн” гэх тодотголтой Засгийн газрын үед өөртөө зориулж шинэ албан тушаал хүртэл гаргуулж байсан эрхэм. Гэвч тэр өнгөрсөн хугацаанд Засгийн газрын үйл ажиллагаагаар газар дор ортол муулсан ярилцлагуудыг байнга өгч, хэвлэлээр гаргадаг байлаа. Түүнийх нь хэтийн зорилго энэ байж. Одоо түүнд Монголд хашаад байх албан тушаал байхгүй. Тийм болохоор хүйтэн, утаа хоёроос зайлж, дулаан газар дураараа жарган суух эрхээ олж авахын төлөө зүтгэсэн нь нийм аягаар бүтэж байж болох юм. Тэр Шведэд суух Элчин болж чадлаа. УИХ-ын гишүүн асан З.Алтай уг нь тэнд Элчин сайдаар сууж байгаа. Гэвч түүнийг хугацаанаас нь өмнө эргүүлэн татаж, М.Энхсайханыг явуулж байна.

**MMINFO** Тал нутгийн цахим мэдээлэл

### ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Тавьсан эдийн засагч Б.Мэдэрээ

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

## УЛС ТӨР

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА



## Н.Амарзаяа:

...Албан бус бүлгийг байгуулсан, манай НАМЭХ-ны дарга Ц.Цогзолмаа дарга ахлаад явж байгаа. Улс төрийн акц гэхээсээ илүүтэй олон бодит байдлыг олж олон салбар чиглэлээр уулзалт, арга хэмжээг хийж, байгаа газар дээр нь очиж үзэж зохих төвшинд ажиллаж байна. Сүүлийн үед анхаарал тавьж ажиллах асуудал охид, залуучуудын дунд, нийгмийн дунд ч нилээд байна...

Ер нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүд 2012 онд 3.5 их наяд төгрөгийн өртэй байсан бол 2015 онд 10.8 их наяд төгрөгт хүрч өссөн. 2016 оны хоёрдугаар улирлын байдлаар 38.6 тэрбум төгрөгийн өртэй гарсан нь ТУЗ-ийн болон удирдлагын хариуцаагүй шийдвэртэй холбоотой.

-Ирэх онд манай улс ихээхэн хэмжээний өр төлнө.

удаагийн томилолт нэлээд үр дүнтэй байсан байх?

-Маш их хүлээлт байсан, Гашуун сухайт хилийн боомтоор бараг 10 гаруй жил нүүрс экспортолож байгаа гэхэд асуудал, бэрхшээл маш их байсан. Сайд маань очиж албаны бүх хүмүүсийн нээлттэй мэдээллийг сонсч, зохих шийдвэрүүдийг гаргаж, үр дүнд хүрсэн. Олон улсын шинж чанартай боомт болохоор шийдвэрлэгдэж байгаа өнөө үед уг боомтын ирээдүйн хөгжлийн асуудал, түүнээ дагаад хөгжих хун амын төвлөрөл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалыг хамтад нь хөгжүүлэх зэргээр бодлогын хэмжээнд авч хэрэгжүүлэх олон асуудал байгаа талаар харилцан ярилцсан. Одоо Засгийн газраас хоёр ч ажлын хэсэг байгуулагдсан.

-Ерөнхий сайд Өмнөговь аймагт ажиллахдаа тэнд үйл ажиллагаа явуулж байгаа Оюутолгой, Эрдэнэс-Тавантолгой, Энержи ресурс, орон нутгийн Тавантолгой зэрэг компанийн удирдлагуудад тодорхой үүрэг өгөх шиг боллоо?

Ерөнхий сайд уурхайн үйл ажиллагаатай танилцаж удирдлагуудад нь үүрэг чиглэл өгсөн. Энэ чиглэл нь ард иргэдийн сэтгэл санаанд нийцсэн бодитой сайн шийдвэр байсанд талархаж байгаа. Ер нь ард иргэдийн бодол санаанд тулгуурласан бодит зөв шийдвэрийг гаргана гэж бид сонгогдсон шүү дээ. Үүний тод илрэл боллоо гэж би дүгнэж байгаа.

-Гашуунсухайтын боомтын ажилчдын амьдрах, ажиллах орчны болон жолооч нарын аюулгүй байдлыг баталгааг хангаж сайжруулах

Судалгаанд суурилсан шийдвэр гаргахыг гол зорилго болгож байна. Урт хугацааны тогтвортой төлөвлөлтийг бий болгох үүнд анхаарлаа хандуулах ч бас бидний л хийх ажил.

-Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосонбумбын асуудал олны анхаарлын төвд байдаг. Та Тост, Тосонбумбын нуруу орчмын газар нутгийн хилийн заагийг тогтоох ажлын явц болон түүний орчимд олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэлийг цэгцлэхээр хийсэн ажлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад асуулга тавьсан байсан. Энэ талаар?

-2016 оны УИХ-ын хаврын чуулганаар Гурвантэс сумын Тост, Тосон бумбын нуруут улсын тусгай хамгаалалтад аваад харин хилийн цэсийг нь тогтоогоогүй юм билээ. Ард иргэдийнх нийтлэг санал бол энэ тогтоолыг эцэслэн шийдвэрлүүлэх саналтай байгаа. Тэгээд энэ асуудлыг хуулийн дагуу Засгийн газар тогтоодог, эцэслэн шийдвэрлэдэг болохоор асуулга тавьсан.

-Эмэгтэй гишүүн болоод ч тэр үү, та чуулган байнгын хорооны хурал дээр эрүүл мэнд, боловсролын асуудлыг нэлээд хөндөж байгаа харгагддаг?

-Орон нутагтаа энэ салбарынхаа хэмжээнд судалгаа хийсэн. Нөхцөл байдал амаргүй хүнд байна. Ард иргэдийн бухимдаад байгаа асуудлын гогцоо нь энэ хоёр салбараар үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамж хангалтгүй байгаатай холбоотой. Хүүхдийн энэг, эхээс ч, төр засгаас ч зардал мөнгө гаргаад л зарцуулаад л байдаг. Тэгээд байхад яагаад хүүхдүүдийн маань

# МАНАЙ УЛС ТОМООХОН МЕГА ТӨСЛҮҮДЭЭ ЗОРИГТОЙ ХӨДӨЛГӨХ ЦАГ НЬ БОЛСОН

Ж.ОТГОН

УИХ-ын гишүүн  
Н.Амарзаяатай ярилцлаа.

**Монгол улсын ирэх оны төсөв 2.6 их наяд төгрөгийн алдагдалтай батлагдлаа. Таны бодлоор энэ удаагийн төсвийг юу гэж дүгнэж байгаа вэ?**

-2016 оныг бодвол боломжийн төсөв батлагдлаа. Нэгдсэнтөсвийн нийт тэнцвэржүүлсэн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ 2016 онд 18 хувь байсан бол 2017 оны төсөвт 9.1 хувь байхаар баталлаа. Энэ нь төсөв ямар болсныг дүгнэж байгаа дүн.

**Дэлхийн зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унаж байна. Ийм үед төсвөө уул уурхай дээр түшиглэн төсөвлөх нь хэр оновчтой юм бол?**

-Ер нь манай улс сүүлийн арав гаруй жил зөвхөн уул уурхайд

түшиглэсэнтөсөвтэйявлаа. Түүхий эд унахаар дагаад унадаг, хамгийн их уналттай нь сүүлийн хоёр жил. Харин одоо дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өсөх хандлага ажиглагдаж байна. Гэхдээ ойрын жилүүдэд уул уурхайн орлогод тулгуурлан экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төсвийн орлогын 50-70 орчим хувь нь тогтвортой өсөлт бүхий эдийн засгийн төрөлжсөн зөв бүтэц рүү орох талаар бид бодлогоо чиглүүлэх хэрэгтэй.

**Томоохон мега төслүүдээ хөдөлгөнө гэж ярьж байгаа ч тэр нь хурдан хугацаанд үр шимээ өгөхгүй учир эдийн засгийг хөл дээрээ босоход шууд нөлөөлөхгүй гэж үзэх хүмүүс байна?**

-Зоригтой хөдөлгөх цаг нь болсон. Тухайлбал, Тавантолгойн цахилгаан станцыг барьж байж Оюутолгой дотоодын эх үүсвэрт холбогдож жилдээ гадагшаа

урсдаг 4000 орчим тэрбум төгрөгийн урсгал дотооддоо шингэнэ. Тавантолгой төмөр замыг яаралтай барьж байж түүхийгээр нь зөөгөөд байгаа нүүрсээ гуравдагч орон руу гаргаж үр ашгаа хүртэнэ. Ойрын хоёр жилдээ бол шууд нөлөөлөхгүй нь үнэн, 2019 оноос эхний төслүүдийн үр дүн эхлэх болов уу.

**Төсвийн асуудал яригдаж байхад та ТУЗ-ын гишүүдийн асуудлыг хөндөж байсан. ТУЗ-д орон нутгийн хүнийг сонгох боломж бий юу?**

-Бүрэн боломжтой. Энэ бол эргэх холбоотой харилцан хамаарал бүхий хариуцаагатай асуудал, нөгөө талаар тухайн төрийн өмчийн үр ашигтай байдал, хамгаалалт мөн орон нутгийн ард иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хэрхэн хүрч байгаа талаар бодит мэдээлэлд тулгуурлаж ТУЗ-ийн шийдвэр гарах бодит боломжтой.

**Төлөх өрийнхөө хэмжээтэй дүйцэхүйц бонд гаргах талаар яриад байгаа. Энэ хэр зөв гарц вэ?**

-Нэмж бонд гаргахыг би дэмжихгүй байгаа. Энэ бол буруу гарц. Харин өрөө нягтлан үзэж хугацааг сунгаж, хүүг нь бууруулах талаар анхаарах нь зөв байх. 2017 оны төсвийн байдлыг харахад, юун өр төлөх орлого хаана байна гэхээр л байна шүү дээ.

**“Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах нь нэгэнт тодорхой болж байх шиг байна. Уг хөтөлбөр хэрэгжих нь улс орны төсөв нэг байгууллагын хараа хяналтад орно гэсэн болгоомжлолыг төрүүлж байгаа. Та энэхүү хөтөлбөрт хамрагдахыг дэмжиж байгаа юу?**

-Дэмжиж байгаа. Харин ч цаг хугацааны хувьд нилээд оройтож байна гэж дүгнэж байна. ОУВС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь төр, засгийн байгууллагын хамтын зорилго, улс төрийн тогтвортой байдал гээд нилээд олон боломжуудад тулгуурлан хямралыг богино хугацаанд даван туулах боломжтой гэж үзэж байна. Харин энэ хөтөлбөрт хамрагдсанаар тавигдах шаардлага нөхцөлийг даруй засч, төсвөө эрүүл, сахилга баттай болгож, төлбөрийн балансын тэнцлийг хангах, ДНБ-д эзлэх төсвийн алдагдлыг бууруулах зэргээр анхаарах нь чухал.

**Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Өмнөговь аймагт ажиллаж, уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүдийн ажилтай танилцаад ирсэн. Энэ**

**шаардлагатай гэдгийг сайд хэлсэн байсан. Энэ талаар цаашдаа ямар ажил хийгдэх бол?**

-Асуудал их байна. Төр ард түмнийхээ төлөө үйлчлэх үүрэгтэй. Тэнд төрийн албан хаагчид ч хүнд байна, уух ус алга, амьдрах байр алга, импортоор цахилгаанаа авч байна, мөнгөө өгөхгүй бол цахилгаана таслуулдаг, амьдрал бэрх байна. Тэнд жирийн наймаа хийж байгаа хүмүүс, жолооч нар, үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн хүмүүс хүнд халуун цэгт байна. Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсэг, аймаг орон нутгийн удирдлагууд маань нилээд дорвитой шинэчлэл, хөгжлийн төлөө зорих байх, цаг хугацаа нилээд орно. Гэхдээ амаргүй гээд хойш суухгүй байх.

**Өнгөрсөн сард та тойрогтоо ажиллаад ирсэн. Төр засгийн бодлогын төвшинд дэвшүүлэх асуудал хэр олон байв. Мэдээж анхаарч ажиллах арга хэмжээний болон хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлаа цэгцлээд ирсэн байх?**

-Өнгөрсөн аравдугаар Шадар сайдтай орон нутагт тойргоороо ажилласан. Ард иргэдтэйгээ уулзсан. Төрийн байгууллагуудаар орж, үйл ажиллагаатай нь танилцсан. Ажил хэвийн сайхан төсвөө эрүүл, сахилга баттай баримталдаг зарчим байдаг юм. Баг, сум, аймагт амьдарч байгаа Монгол улсын иргэн бүрт хэрэгтэй, шаардлагатай байгаа асуудлыг нь тухай бүр нь шийдвэрлэх, чирэгдэлгүй үйлчлэх боломж нөхцөлийг хангах ажиллах нь төрийн албан хаагч бүрийн үүрэг байх ёстой.

амжилтын чанар муудаад, сурах идэвхи сонирхол нь буураад, бүгд тэгш бус оролцоотой байна вэ. Үүнтэй холбоотой иргэдийн боловсрол, эрүүл мэндийн талаарх нийгмийн сөрөг хандлагууд ихсээд байгааг нэг дүгнэх хэрэгтэй байна. Мөн аав ээжийн үед байсан эмнэлгүүд яг л хэвээрээ хэрнээ яагаад заавал аймаг руу орж төрдөг, хот руу орж хагалгаанд ордог, гадаад явж эмчлүүлдэг болоод байна вэ. Хүмүүс арай илүү чанарлаг үйлчилгээ авахыг л хүсээд байна шүү дээ. Үүнийг л анхаарч төрийн эдгээр нийтлэг үйлчилгээнд чанарын өөрчлөлт хийх цаг нь болсон.

**Өмнөх парламентын эмэгтэй гишүүд нэгдэж, хүүхэд, эмэгтэйчүүдтэй холбоотой эмэгт асуудалд хүчтэй дуугарч, улс төрийн акц үзүүлдэг байсан. Энэ парламентын эмэгтэй гишүүдийн тоо олон болсон. Тиймээс 13 эмэгтэй гишүүн албан бус бүлэг байгуулаад явж болдоггүй юм уу?**

-Албан бус бүлгийг байгуулсан, манай НАМЭХ-ны дарга Ц.Цогзолмаа дарга ахлаад явж байгаа. Улс төрийн акц гэхээсээ илүүтэй олон бодит байдлыг олж олон салбар чиглэлээр уулзалт, арга хэмжээг хийж, байгаа газар дээр нь очиж үзэж зохих төвшинд ажиллаж байна. Сүүлийн үед анхаарал тавьж ажиллах асуудал охид, залуучуудын дунд, нийгмийн дунд ч нилээд байна. Шинжлэх ухааны салбараа ч хөгжүүлэх, мэдлэгт суурилсан шинэчлэлт өөрчлөлтийг хөхүүлэн дэмжих, их сургуулиуд дахь чанарын шинэчлэлийг бодитой болгох гээд л асуудлууд цөөнгүй байна даа.

## ЭЛСЭЛТИЙН ЗАР

“Зохномж” дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй

7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

**Жич:**

- IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нөхүүлнэ
- Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.  
Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021

# MMINFO.

Тал нутгийн цахим мэдээлэл



# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# БИЧИН ЖИЛИЙН ӨВӨЛ БЯД ШАЛГАЖ ЭХЭЛЛЭЭ

Шадар сайд

У.Хүрэлсүхийн тэргүүлсэн Улсын

Онцгой комиссын хуралдаан энэ сарын 16-нд болж, сүүлийн хэд хоногт орсон их хэмжээний цас нийт нутгийн 30 гаруй хувийг хамарч, өвөлжилт хүндэрч болзошгүй болсон талаар мэдээлсэн. Ингэхдээ зуд тохиолдож болзошгүй аймгуудад Увс, Дорнод, Төв, Хэнтий, Дархан, Сэлэнгийн ихэнх сумд, Завханы хойд, Булганы зүүн өмнөд, Хөвсгөлийн баруун хэсэг хамаарч байна хэмээн онцлохын зэрэгцээ Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс энэ сарын 17-25-ныг хүртэлх хугацаанд манай оронд сүүлийн 10 гаруй жилд ажиглагдаагүй онцгой хүйтэн болох төлөвтэйг мэдээлсэн. Бүр зарим газраар -42-47 хэм хүрч, Сибирийн хүйтэн уур амьсгал орж ирж буй талаар ч анхааруулсан. Тиймээс энэ удаагийн "Онцлох хуудас" булангаараа цаг агаарын байдал, орон нутгийн нөхцөл байдлын талаар бэлтгэлээ.

### ЦАСАНД БООГДСОН ИРГЭДИЙГ АВРАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

**2016.11.20:** ОБЕГ-аас энэ сарын 19-ний шуурхай албаны мэдээг нэгтгэн гаргаад байна. Үүнд, Ховд аймгийн Цэцэг сумын Баян-Овоо багийн нутаг Цагаан-Эрэг гэдэг газарт хувиараа чулуу олборлож байсан 60 хүн, 12 автомашины шатахуун дуусч, Богосын даваанд цасанд боогдсон гэх дуудлагын дагуу эрэн хайх ажиллагаа явуулж, цасанд боогдсон иргэдийг олжээ. Иргэд айлуудын зуслангийн хашаа саравчинд хоёр гэр барьж хонож байсан аж. Мөн Ховд аймгийн Булган сумын Баянгол багийн Жаргалантын-Аманд цасанд боогдсоны улмаас иргэд явж чадахгүй байна гэсэн дуудлагын онцгой байдлынхан ажиллаж, иргэдийг эсэн мэнд гэрт нь хүргэсэн байна. Үүнээс гадна нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Хонхорын цахилгаан станцын хажууд автомашин цасанд суусан байна гэсэн дуудлагын дагуу аврах ангийнхан ажиллаж, иргэн Д-ийн "Соната-6" загварын автомашин цасанд суусан байсныг гарган аюулгүй болгожээ.

### ШУУРХАЙ МЭДЭЭ: СЭРЭМЖЛҮҮЛЭГ

**2016.11.18:** Цас их орсны улмаас цаг агаарын байдал хүндэрч энэ сарын 18-ны өдрийн 17:30 цагийн байдлаар Улаанбаатараас Дорноговь, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Дархан, Эрдэнэт, Булган, Сэлэнгэ, Хөвсгөлийн чиглэлд их хэмжээний цас шуурч үзэгдэх орчин хязгаарлагдсан байдалтай байгаа тул онц шаардлагагүй тохиолдолд дээр дурьдсан чиглэлүүдэд зорчихгүй байхыг анхааруулж байна. Мөн цаг агаарын байдал хүнд байгаатай холбогдуулан хөдөө, орон нутгийн бусад чиглэлд зорчихдоо замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцож хувийн болон хууль бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхгүй байхыг Автотээврийн үндэсний төвөөс анхааруулав.

### ЗАРИМ АЙМГУУДААС ГАРАХ ЗАМ ХААЛТТАЙ БАЙНА

**2016.11.19:** 2016 оны арваннэгдүгээр сарын 19-ний өдөр, 00:30 цаг: Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан их хэмжээний цас орж, зам даваанд хальтиргаа, гулгаа үүсч автотээврийн хэрэгсэл аюулгүй зорчих боломжгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг болзошгүй эрсэдлээс урьдчилан сэргийлж Зам, тээврийн хөгжлийн сайдын 92 дугаар тушаалаар дараах чиглэлд автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлалаа. Үүнд Улаанбаатар хот, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн төвөөс гарах ачаа, нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2016 оны арваннэгдүгээр сарын 18-ны өдрийн 23:00 цагаас 19-ний өдрийн 08:00 цаг хүртэл, Завхан аймгийн Улиастай сумаас гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 18-ны өдрийн 23:00 цагаас 19-ний өдрийн 10:00 цаг хүртэл зогсоож, Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн авто зам, замын байгууламжийг хаалаа. Мөн цаг агаарын байдал хүнд байгаатай холбогдуулан хөдөө, орон нутгийн бусад чиглэлд зорчихдоо замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцож хувийн болон хууль бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхгүй байхыг Авто тээврийн үндэсний төвөөс мэдээллээ.

### УЛААНБААТАР, ДАРХАНЫ ХООРОНД РЭЙЛБУС ЗОРЧИЖ БАЙНА

**2016.11.20:** Нийт нутгаар их хэмжээний цас орсны улмаас хөдөө, орон нутгийн авто замуудад хальтиргаа гулгаа үүсч, замын нөхцөл байдал муу байна. Гэхдээ одоогоор зам даваа хаагдаагүй, тээврийн хөдөлгөөн хэвийн үргэлжилж байгаа гэж Авто тээврийн үндэсний төвөөс мэдээллээ. Ус цаг уур орчны шинжилгээний газрын мэдээллээр энэ сарын 17-25-ны өдрүүдэд цас үргэлжлэн орж, цаг агаарын нөхцөл байдал хүндэрч төлөвтэй байгаа юм. Иймд орон нутгийн автозамд зорчиж байгаа иргэд замын хөдөлгөөндөө анхаарал болгоомжтой оролцохыг сануулахын зэрэгцээ дээрх нөхцөл байдалтай уялдуулан хот хоорондын зорчигч тээвэрт шинэ зохицуулалт хийсэн байна. Энэ хүрээнд Улаанбаатар-Дархан-Улаанбаатарын чиглэлд рэйлбусаар төмөр замын тээвэрлэлт хийхээр болжээ. Зорчигчийн хөлс нэг талдаа 15 мянган төгрөг байсныг туршилтаар 10 мянган төгрөг болгон бууруулсан гэдгийг "Улаанбаатар Төмөр зам" компаниас мэдээллээ. Түүнчлэн хойд чиглэлийн зорчигч тээврийн галт тэрэгний тоог нэмж, тасалбарын худалдааг галт тэргэнд суусны дараа хийж байх шинэ зохицуулалт хийхээр төлөвлөжээ.



### ЗАРИМ СУМ ЗУДЫН БАЙДАЛД ОРЛОО

**2016.11.20:** Ховд аймгийн Булган суманд энэ сарын 08-ны өдрөөс өнөөдрийг хүртэл цас үргэлжлэн орсны улсаас тус сум зудын байдалд оржээ. Энэ нөхцөл байдлыг давж гарахаар сумын Засаг дарга Б.Амгаланбадрахаар ахлуулсан ажлын хэсэг зохих арга хэмжээг авч ажиллаж байгаа гэнэ. Одоогийн байдлаар Булган сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 100 см цасан бүрхүүл тогтсон, зам харгүй хаагдсан, эрсдэлтэй орчинд тусгаарлагдсан 333 хүн, 97744 толгой малын амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учрах нөхцөл үүсээд байгаа аж. Тус сумын удирдлагууд аймгийнхаа онцгой комисст хүсэлт тавьж, сурагчдын хичээлийг долоон хоногоор хойшлуулах шийдвэр гаргуулсан байна. Мөн тус суманд үүссэн нөхцөл байдал сумын дотоод хүчин чадлаас давсан учир өвс тэжээлийн асуудалд анхаарах, үүнээс үүдэн малчид малаа цөөлөхөөр нядалгаанд оруулж байгаа учир малын махыг улсын нөөцөд авч борлуулахад туслах, айл өрхүүд түлшний хомсдолд орж болзошгүй байгааг харгалзаж Хөшөөтийн уурхайгаас хямд үнээр нүүрс татаж айл өрхийг нүүрсээр хангах, цасанд боогдсон мал хүнийг татаж авахад шаардагдах шатахууны асуудлыг шийдэх, хүн эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар орон нутгийн удирдлагууд Улсын онцгой байдлын комисст хүсэлт гаргажээ.

## Сэтгүүлчийн өнцөг

# СЭРЭМЖЛҮҮЛГИЙН ДУУТ ДОХИОГ ОНЦГОЙ ҮЕД Л АШИГЛАЯ

Э.ТУУЛ

Өнгөрсөн хэд хоног орсон цас ёстой л нэг өвлийг мэдрүүлж байна даа. Ойрын хэдэн жилд ийм их хэмжээгээр орсон цас хараагүй нийслэлчүүд эхнээсээ шалгалтад бүдэрч, цасаа цэвэрлэж чадахгүйд хүрчихээд аргаа бараад сууж байна. Замын нөхцөл байдал хүндэрч, хэдэн тээврийн хэрэгсэл нь мөлхөх шахам хөдөлгөөнд ороцож, зарим нэг нь машинаа зогсоож хүчрэхгүй осол гаргасаар л байна. Нийслэлд нэг иймэрхүү дүр зурагтай хэдэн өдрийг өнгөрөөлөө. Харин хөдөө, орон нутагт бол бүр ярих ч юм алга. Зарим зам даваа хаагдаж, хэд хэдэн аймгийн сумдад

зудын байдал нүүрлэж, олон хүн тээврийн хэрэгсэлтэйгээ цасанд сууж, осгох шахсан дуудлагууд Онцгой байдлынханд ирсээр л байгаа талаар мэдээлж байна. Үүндээ цаг агаарын урьдчилсан мэдээллээр ойрын хэд хоног хүйтний эрч чангарч, зарим газраар -42-47 хэм хүрч, Сибирийн хүйтэн уур амьсгал орж ирж буй талаар ч анхааруулж буй. Тиймээс ч Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын тушаалаар томилогдсон ОБЕГ-ын ажлын хэсгүүд аймгуудын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцах, эрсдэлийн үнэлгээ хийх, орон нутаг бие даан эхний ээлжийн харну арга хэмжээ авах талаар мэргэжил арга

зүйн зөвлөгөө өгөх зорилгоор орон нутагт ажиллаж байна. Мөн аймгийн онцгой комиссын өргөтгөсөн хурлыг хийж, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, төв суурин газрын бэлэн байдлыг хэлэлцүүлж, улсын нөөцийн салбартай танилцан, аймгийн Засаг дарга нарт зөвлөмж өгч эхэлжээ. Мөн малчидтай уулзаж, нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцаж байгаа гэнэ. Ерөнхийдөө хэдэн өдөр дараалан орсон их цаснаар бичин жилийн өвөл хатуу болох талаар энд тэндгүй л ярьж буй. Өнөө хэдэн малчид маань ч цас зуданд хэдэн малаа алдчихгүйн тулд турь бяд

муутай хэдэн хонь, үхрээ янзалж, хот руу зүглэж, хөдөлгөөнийг эрс нэмэгдүүлдэг байгаа сурагтай. Бас манайхны зарим хэнэггүй нөхдүүд үзэгдэх орчин муу, хальтиргаа гулгаа ихэссэн, зам даваа хаагдсан талаар ЗЦГ, онцгой байдлынхныг сэрэмжлүүлсээр атал тоож байгаа ч юмгүй эвдрэлтэй тээврийн хэрэгслээ унаад л энд тэнд төөрөөд, цасанд суугаад л амь нас, эд хөрөнгийг минь авар гэж уйлан донгодох нь ихэсч байна. Сэрэмжлүүлж сануулж, нийслэлээс орох, гарах замыг нь хүртэл хаачихаад байхад хулгайн замаар гарч давхиад л ийм байдалд хүрчихээд байгаа хүмүүсийг юу гэх вэ. Ийм л хэнэггүй, ухамсаргүй нөхдөөс

болж, онцгой байдлынхан ачааллаа дийлэхгүй өдөр шөнөгүй ажиллаж, улсын өч төчнөөн хөрөнгө мөнгө урсаж байна. Угтаа бол цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангалттай л мэдээлж байгаа. Гэтэл энэ бүх сэрэмжлүүлэг хүмүүст хүрэхээ больчихжээ. Дээхэн үед цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ явахаар нэг л сүрдэм, аймаар дуут дохио телевиз, радиогоор эхэлж явдаг байсан даа. Тэр дуут дохиог сонссон л бол хольн замд явдаг тээврийн жолооч нар хүртэл хуваарна өөрчилж, цаг агаарын байдлыг харнадаг байсан юмдаг. Гэтэл өнөөх дуут дохио нь

өнөөдөр үнэтэй брэнд дэлгүүрийн хямдралыг сурталчилж эхэлснээр үнэ цэнээ алдаж, хүмүүс ч тоохоо больчихжээ. Угтаа бол сэрэмжлүүлгийн дуут дохиог онцгой үед л ашигладаг биз дээ. Яагаад хувийн нэг дэлгүүрийн хямдралын сурталчилгаанд тэр онцгой үед ашиглах ёстой дуут дохиог ашиглуулаад байгаа юм бэ. Цаг агаарын онцгой нөхцөл байдлыг мэдээлэх үед тэр дуут дохиог явууллаа гэхэд хүмүүс тэр дэлгүүрийн сурталчилгааг л явж байна гээд тоолгүй өнгөрч, сувгаа солих магадлал өндөр байна. Тиймээс онцгой үед ашиглах ёстой зүйлээ өөр газарт ашиглуулахыг хориглохыг санал болгож байна.

# ДЭЛХИЙ

## АНУ-ЫН 45 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧ Д.ТРАМПЫН КАБИНЕТ ЯМАР БАЙХ ВЭ



**Төгсгөл.**  
**Түрүүч нь I нүүрт**

### АНУ-ын Тагнуулын төв газрын дарга

Үл хөдлөх хөрөнгийн магнат Доналд Трамп АНУ-ын Тагнуулын төв газрын даргын албан тушаалд Майк Помпеог томилжээ. Түүний хувьд Кансас мужийн ИТХ-д сонгогдож байснаас гадна армийн офицероор ажиллаж байсан туршлагатай аж. Мөн Тагнуулын төв хорооны гишүүнээр ажиллаж байхдаа Ливийн Бенгази хотод 2012 онд болсон халдлагатай холбогдуулан Хиллари Клинтоньг хурцаар шүүмжилж байжээ. Доналд Трамп Ерөнхийлөгч болсныхоо дараа АНУ-ын аюулгүй байдалд олон талт, цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээ амласан удаатай. Тиймээс шинэ Тагнуулын төв газрын дарга одоогийн тэргүүн Жон О Бреннаны энэ жилээс хэрэгжүүлж эхэлсэн "шинэчлэл"-ийн төлөвлөгөөг цуцлахаас гадна эсрэгээр хатуу байдалт явуулах арга барил буюу эрүүдэн шүүлтэйг дахин сэргээж болзошгүй хэмээн зарим ажиглагчид таамаглаж байгаа юм.

### Ерөнхий прокурор

Доналд Трамп сонгуулийн сурталчилгааныхаа үеэр Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтоньг "шоронд явуулна" хэмээн сүрдүүлж байсан удаатай. Тэгвэл Ерөнхий прокуророор өөрийн талын хүнийг томилсноор түүний хууль, шүүхийн байгууллагыг шинэчлэх мөрийн хөтөлбөр биелэх боломжтой болно. Тэгвэл энэ албан тушаалд Трамп Алабама мужийн сенатч Жефф Сешнсг томиллоо. Жефф Сешнс шинээн төрийн тэргүүний цагаачлалын эсрэг бодлогыг дэмжигч юм.

### Үндэсний аюулгүй байдлын зөвлөх

Үндэсний аюулгүй байдлын зөвлөх бол кабинетын гишүүн биш. Гэхдээ Төрийн департамент болон Пентагон, бусад агентлагуудын гаргасан санал шийдвэрүүдийн чухал хянагч нь юм. Доналд Трамп цэргийн алба хаасан туршлагатай нэгэн. Тиймдээ ч, Батлан хамгаалах хийгээд үндэсний аюулгүй байдлын салбарт ихээхэн анхаарал хандуулж байгаагийн илрэл нь Майкл Т.Флиннийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөхөөрөө томилсон явдал юм. Майкл Флинн тэтгэвэртээ суусан армийн генерал бөгөөд Батлан хамгаалах яамны Тагнуулын агентлагын даргаар ажиллаж байв. Тэрбээр Доналд Трампын лалын улс бүлэглэлийн эсрэг үзэл баримтлалыг тууштай дэмжигч ажээ.

### Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга

Цагаан ордны албан хаагчдын

дарга буюу Ерөнхийлөгчийн тамгын газрын даргаар Бүгд Найрамдах намын /БНН/ Үндэсний хорооны дарга Райнс Прибусыг томилсон байна. Тэрбээр штабын ажлыг удирдахаас гадна Ерөнхийлөгчийн хэлэлцэх асуудал, төлөвлөгөөг удирдан зохион байгуулах үүрэг хүлээсэн хүн юм. БНН-ын удирдлагатай ойр харилцаатай байдаг Р.Прибусыг дээрх албан тушаалд томилсон нь Д.Трамп нам доторх санал зөрчилдөөнийг намжааж, өөрийн засаг захиргааны ажлыг аядуу тайван байдлаар эхлүүлэхийг хүсч байгааг харуулаа гэж ажиглагчид үзэж байна. Энэ нь Трампын хувьд мөн л чухал томилгоо байв.

### Ахлах зөвлөх

Доналд Трамп өөрийн ахлах стратегич буюу ахлах зөвлөхөөр Стивен Бэннонийг томилжээ. С.Бэнноны хувьд Д.Трампын сонгуулийн штабын даргаар ажиллаж байсан юм. АНУ-ын баруун жигүүрийг баримтлагч "Брейтбарт" хэвлэлийн ерөнхий захирлаар ажиллаж байсан тэрбээр БНН-ын бүтэц үйл ажиллагааг шүүмжлэгч бөгөөд намын зарим гишүүд нь түүнийг арьс онгоор ялгагарлан гадуурхагч гэж нэрлэдэг байна.

### Төрийн нарийн бичгийн дарга

Одоогоор Доналд Трампыг Ерөнхийлөгчийн тангарагаа өргөсний дараа Төрийн нарийн бичгийн даргаар хэн ажиллах нь тодорхойгүй байгаа ч, олны анхаарлын төвд буй томилгооны нэг нь яах аргагүй мөн. Тэгвэл хамгийн сүүлд авсан мэдээллээр эл албан тушаалд томилгодох магадлал өндөртэй эрхмүүдийн тоо аль хэдийнэ долоо болсон байв. Тодруулбал, Ерөнхийлөгч асан Жорж В.Бушийн үед НҮБ-д төлөөлөгчөөр сууж байсан Жон Р.Болтон, Сенатын Гадаад харилцааны зөвлөлийн дарга, Теннеси мужийн сенатч Боб Коркер, Нью-Йорк хотын захирагч асан Рудольф В.Жулиани, Өмнөд Каролина мужийн захирагч Никки Р.Халей, АНУ-аас Афганистанд суух Элчин сайд асан Залмай Халилзад, Афганистан дахь цэргийн командлагч асан Стэнли МакЧристал, Массачусетс мужийн захирагч асан, 2012 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас дэвшигч Митт Ромни нарын нэр тус албан тушаалд яригдаж байна. Гэхдээ хамгийн магадлал өндөртэй нь Митт Ромни байгаа тухай эх сурвалжууд онцолж байгаа юм. Учир нь саяхан Доналд Трамп түүнтэй голфын талбайд уулзсан гэнэ. Тэд ойролцоогоор 90 минут орчим уулзсан ч, аль аль нь Төрийн нарийн бичгийн даргын томилгооны тухай сэтгүүлчдэд үг унаагаагүй ажээ.

### Төрийн сангийн нарийн

### бичгийн дарга

Төрийн сангийн нарийн бичгийн дарга санхүүгийн зах зээл дэх Засгийн газрын зээл, татварын хууль тогтоомжийг дахин боловсруулахад хийгээд дотоодын орлогод хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ. Мөн Төрийн сан нь гадаадын зарим орнуудын эсрэг авсан эдийн засгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх болон цуцлах үүргийг гүйцэтгэдэг ажээ. Тэгвэл энэ чухал албан тушаалд одоогоор дөрвөн эрхмийн нэр яригдаж байна. Тухайлбал, Колони капитал хөрөнгө оруулалтын фирмийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Томас Баррак, Техасын төлөөлөгч, Цагаан ордны Санхүүгийн хорооны дарга Жеб Хенсарлин, Д.Трампын сонгуулийн кампанитын санхүүжилт хариуцсан дарга Стевен Мнучин, Миннесота мужийн захирагч асан Тим Пауленти нарын хэн нэгэн нь уг албан тушаалд томилгодож магадгүй байгаа юм.

### Баглан хамгаалахын нарийн бичгийн дарга буюу Нентагоны дарга

Шинээр томилогдох Батлан хамгаалахын нарийн бичгийн дарга цэргийн үйл ажиллагаа хийгээд Лалын улс бүлэглэлийн эсрэг явуулж буй арга хэмжээнд хяналт тавих үүрэг хүлээнэ. Тэгвэл энэ албан тушаалд Ирак, Афганистаны дайнд армийн офицерын үүрэгтэйгээр оролцож байсан Аркансас мужийн сенатч Том Коттон, Үндэсний аюулгүй байдлын зөвлөх асан Стефен Хадди, Ирак, Афганистаны дайнд усан цэргийн офицероор ажиллаж байсан Дункан Хантер, Аризона мужийн сенатч асан Жон Кил, АНУ-ын Төв командлалын командлагч асан Жэймс Маттис нар нэр дэвшиж байна.

### Дотоод хэргийн нарийн бичгийн дарга

Энэ албан тушаалд нийтдээ дөрвөн хүний нэр одоогийн байдлаар яригдаж байгаа юм. Тодруулбал, Аризона мужийн захирагч асан Жан Бревер, хөрөнгө оруулагч Роберт Грэйди Грифон, Аласка мужийн захирагч асан Сара Палин, Лукас газрын тос, хийн компанийн гүйцэтгэх захирал Харолд Хамм нар нэр дэвшиж байгаа юм байна.

### Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга

Дараагийн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга АНУ-ын аж ахуйн салбарт хяналт тавьж, хүнсний бүтээгдэхүүний чанарыг шалгаж, орлогод зуурилсан хүнсний туслашцаа үзүүлэг чиг үүргийг гүйцэтгэнэ. Тэгвэл энэ албан тушаалд Кансас мужийн захирагч Сэм Браунбэк, Фермерүүдийн хоршоодын Үндэсний зөвлөлийн гүйцэтгэх

захирал Чук Коннер, Техасын хөдөө аж ахуйн комиссар Сид Миллер, Жоржиа мужийн захирагч асан Сонни Перди нарын нэр яригдаж байна.

### Худалдааны нарийн бичгийн дарга

Худалдааны нарийн бичгийн албан тушаалд одоогийн байдлаар хоёр эрхмийн нэр яригдаж байгаа юм. Худалдааны яамны зарим үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг гүйцэтгэх энэхүү албан тушаалын төлөө Нукор корпорацийн гүйцэтгэх захирал асан Дан ДиМикко, Гранит Капитал группын

ерөнхийлөгч Луйс Эйсенберг нар нэрээ дэвшүүлжээ.


### Хөдөлмөрийн нарийн бичгийн дарга

Хөдөлмөрийн яамны хууль дүрмийн дагуу хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашгийг тэтгэмжийг олгох хийгээд сар бүр ажлын байрны эдийн засгийн тайлан мэдээллийг гаргах үүрэг бүхий энэхүү албан тушаалд 2010 оноос хойш Америкийн иргэдийг ажил эрхлэх тэгш боломжоор хангах комиссын комиссараар ажиллаж буй Викториа Липник гэх эмэгтэй нэр дэвшээ.

### Боловсролын нарийн бичгийн дарга

АНУ-ын шинэхэн Ерөнхийлөгч Доналд Трамп Боловсролын яамны үйл ажиллагааг танах бодлого баримталж буй аж. Энэ утгаараа төрийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжид сургалт судалгаа, хөгжил, боловсролын тусламж үйлчилгээний асуудлыг шилжүүлэх байр суурьтай байгаа юм байна. Тэгвэл дараагийн Боловсролын нарийн бичгийн даргын албан тушаалд Новер институтын боловсролын шинжээч Вильямсон Эверс яригдаж буй ажээ.

## ЭМГЭНЭЛ



**ЧОЙЖИЛСҮРЭНГИЙН ГУНГААСҮХ (1944-2016)**

Монгол Улсын Ардын зураач, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Улсын Дуурь, бүжгийн Эрдмийн театрын ахмад уран бүтээлч Чойжилсүрэнгийн Гунгаасүх 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр өвчний улмаас ертөнцийн мөнх бусыг үзүүлж, соёл урлагийн салбарт хүнд гарз тохиолоо.

Ч.Гунгаасүх 1944 онд Төв аймгийн Угтаалцайдам сумын Ар Асгат хэмээх газар мэндэлж, 1961-1965 онд Барилгын техникумыг зураг төслийн техникч мэргэжлээр, 1966-1971 онд Ленинградын Театр, киноны дээд сургуулийг театрын зураач мэргэжлээр тус тус төгсжээ.

Тэрбээр ажлын гараагаа 1965 онд Дуурь, бүжгийн театрт конструктор зураачаар эхлүүлэн, Дүрслэх урлагийн дунд сургуульд тайз чимэглэлийн мэргэжлийн багшаар хавсран ажиллаж байв. Ч.Гунгаасүх 1980 оноос УДБЭТ-д ерөнхий зураачаар 21 жил тасралтгүй ажиллах хугацаандаа тус театрын тайзнаа шинээр тавигдсан үндэсний болон дэлхийн сонгодог 27 дуурь, 13 балетын ерөнхий зураачаар ажилласан гайхамшигт уран бүтээлч байлаа.

Мөн Улсын Драммын Эрдмийн театрт "Ээдрээ", "Нандин эрдэнэ" зэрэг драмын 7 жүжиг, "Хэлтгий заяа", "Хоньчин Найдан", "Догшин хутагтын сахиус" зэрэг өргөн дэлгэцийн уран сайхны 7 кино, Төрийн хүндэтгэлийн 20 гаруй концерт, Москвагийн Дэлхийн залуучууд оюутны их наадмын концерт, Полыш, Герман, ОХУ-д болсон Монголын соёлын өдрүүдийн концерт, хөдөө орон нутгийн театруудад 12 жүжиг, хилийн чанадад ОХУ-ын Улаан-Уд, Саха, Красноярскийн дуурь, балетын театруудад 7 дуурь, 10 гаруй балетын жүжгүүдийн ерөнхий зураачаар ажиллахын зэрэгцээ Монголын "Театрын музей"-г санаачлан байгуулж, өөрийн хүч хөдөлмөрөөр тус музейн үзэмрийг баяжуулсан бүтээлч, шинийг эрэлхийлэгч, нэрт уран бүтээлч байсан юм.

Ардын зураач Ч.Гунгаасүх нь Монголын тайз чимэглэлийн урлагт шинэчлэл хийж, уран зургийн чиглэлтэй натуралист чимэглэлийн урлагийг өөрчилж, театрын орон зайн дүрслэлтэй сценографийг Монголд анх удаа өөрийн уран бүтээлдээ баримтлан дуурь, балетын жүжгүүдийн хөгжимлөг, найруулга зүйн талаас уран сайхны шийдлүүдийг нь илүү тодотгосон бүтээлүүдийг хийсэн нь Ж.Вердийн "Травиата", "Турандот", Ц.Нацагдоржийн "Үүлэн заяа", "Гэсэр", Б.Дамдинсүрэнгийн "Учиртай гурван толгой" дууриуд болон П.Чайковскийн "Хунт нуур", А.Хачатуряны "Спартак" балет зэрэг бүтээлд тод харагддаг юм.

Ч.Гунгаасүх нь сайн зураач, уран бүтээлч төдийгүй театр урлагийн зураач бэлтгэх нөр их хөдөлмөрт 10 шахам жил ажиллахдаа, төрийн шагналтай, доктор профессор цолтой олон авьяаслаг шавь, уран бүтээлчдийг төрүүлсэн нэрт сурган хүмүүжүүлэгч хүн байлаа.

Тэрбээр 1982 онд С.Гончигсумлагийн "Үнэн" дууриар, 1987 онд "Риголетто" дуурь, "Корсар" балетаар Соёлын Яамны "Шилдэг уран бүтээл"-ийн шагнал, 1983 онд Д.Намдагийн "Эрдэмтний яриа" жүжгээр Монголын Урчуудын Эвлэлийн Хорооны "Оны шилдэг" уран бүтээлийн шагнал, 1996 онд Театрын шилдэг зураачийн "Гоо марал" шагналыг тус тус хүртэж байсан шилдэг уран бүтээлч байв.

Ч.Гунгаасүх шиг дэлхийн сонгодог ба үндэсний олон дуурь, балет, жүжиг, концертыг Монголын болон гадаадын театрын тайзнаа мэргэжлийн өндөр түвшинд туурвисан зураач онгог хүртэл байгаагүй бөгөөд Монголын театрын урлагт оруулсан түүний нөр их хөдөлмөр, авьяас чадварыг төр засгаас өндөрөөр үнэлж 1991 онд Монгол Улсын "Урлагийн гавьяат зүтгэлтэн", 2005 онд Монгол Улсын "Ардын зураач" цол хүртээж, ойн медалиудаар удаа дараа шагнажээ.

Монгол Улсын Ардын зураач Ч.Гунгаасүхийн авьяас билэг, хөдөлмөрч чанар, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээ, тайз, дэлгэцийн урлагт туурвисан түүний гайхамшигт бүтээлүүд, эелдэг даруу, нөхөрсөг зан чанар нь бидний зүрх сэтгэлд үүрд мөнхрөн үлдэж, урлагийн тэнгэрт тодоос тод байх болно.

**Ц.ЭЛБЭГДОРЖ, М.ЭНХБОЛД, Ж.ЭРДЭНЭБАТ  
Л.ЭНХ-АМГАЛАН, Ж.БАТСУУРЬ, Н.ЭНХБОЛД, А.СУХБАТ,  
Ц.ЭНХБАТ, Ж.БАТЖАРГАЛ, Ё.ОТГОНБАЯР**

# ДОРНОГОВИЙН МЭДЭЭ



Хавсралт дугаар

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

## Т.ЭНХТҮВШИН: ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖИЛ, ДЭВШИЛ БИДНЭЭС ХАМААРАХ УЧРААС УЛСТӨРЖИЖ БОЛОХГҮЙ ШҮҮ ДЭЭ



Гэрэл зургийг Д.ЦОЛГОМОН

Ч.ЧУЛУУН

“Дорноговь аймгийг хөгжүүлэхийн төлөө Засаг дарга болон түүний тамгын газар дангаараа зүтгээд төдийлөн үр дүнд хүрэхгүй. Харин иргэд, бизнес эрхлэгчид, төрийн бус байгууллагуудтайгаа хүч хавсарч,

тэдний дэмжлэгийг авч гэмээнэ амжилтад хүрнэ. Эл амжилтын эх суурь нь төр иргэддээ, аж ахуйн нэгж, байгууллагууддаа хүнд сурталгүйгээр үйлдлэх явдал юм. Ер нь тэдний хийе, бүтээе гэсэн хүсэл эрмэлзлийг дэмжиж ажилласнаар бид хамтдаа хөгжих учиртай. Дорноговьчууд бид

хамтдаа сэтгэл зүтгэлээ нэгтгэн зүтгэх аваас амжилтад хүрдгийн жишээ энэ цонхны цаана сүндэрлэн босч буй шинэ хороолол. Бүхэл бүтэн 260 айлын орон сууц бүхий хорооллыг 100 хоногт амжууллаа шүү дээ.

Үргэлжлэл нь II-III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Дорноговь аймгийн Айраг суманд төлбөр хураах цэг байгуулжээ

Б.ДАВАА

Дорноговь аймгийн Айраг суманд төлбөр хураах цэг байгуулсан байна. Тодруулбал, тус суманд шинээр байгуулагдсан Олон улсын болон улсын чанартай А0102 дугаартай авто замаар зорчиж буй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр хураамж авахаар болжээ. “Айраг төлбөр авах цэг”-ийн үйл ажиллагааг энэ сарын 17-ны өдөр эхлүүлж, байнгын ашиглалтад оруулжээ. Энэхүү төлбөр авах нэгж нь Засгийн газрын хоёрдугаар сарын 15-ны өдрийн 103 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Олон улсын болон улсын чанартай зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ”-ний дагуу зам ашигласны төлбөр хураамжийг “Замын сан”-д төвлөрүүлэн ажиллах юм байна.

## АТГ-ынхан Дорноговь аймагт ажиллаж байна

Авлигатай тэмцэх газрын мэргэжилтнүүд орон нутагт ажиллаж байгаа билээ. Тэгвэл Хяналт шалгалтын албаны дарга, ахлах комиссар Л.Сүх-Очироор ахлуулсан ажлын хэсэг энэ өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажиллаж байгаа аж. Шалгалтын хүрээнд орон нутгийн удирдлагууд, нийт төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, төрийн захиргааны албан хаагч, бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэн, хууль сахиулах байгууллагын албан хаагчдад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хуулийг танилцуулж байгаа юм.

Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг таниулах сургалт зохион байгуулжээ.

# 100 ХОНОГ - ОНЦЛОХ АЖИЛ

2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр этхлэн байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 100 хоног тохиосон билээ. Дээрх хугацаанд аймагын төрийн байгууллагууд өөрсдийн

хийж, хэрэгжүүлсэн ажлаа иргэд, олон нийтэд танилцуулах, сурталчлах зорилгоор “Засгийн газрын 100 хоног” арга хэлжээг зохион байгуулсан. Энэ хүрээнд Дорноговь аймгийн Засаг

даргын Тамгын газар, аймагын Засаг дарга Т.Энхтүвшин хийж хэрэгжүүлсэн ажлаа “Аймагын Засаг даргын 100 хоногийн онцлох ажил”-аар хүргэж байна.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА АЖЛАА ХҮЛЭЭЖ АВЛАА

Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны долдугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар захирамжаар Дорноговь аймгийн Засаг даргаар Төмөртогоогийн Энхтүвшин томилогдож ажлаа хүлээж авлаа.



АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ 85 ЖИЛИЙН ОЙН БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Аймаг байгуулагдсаны 85 жилийн ойн баяр наадмыг долдугаар сарын 29, 30-ны өдрүүдэд Сайншанд хотноо өргөн дэлгэр зохион байгуулав.



ГУРВАН УЛСЫН ТРАНЗИТ ТЭЭВРИЙН ЦУВАА ДОРНОГОВЬ АЙМГИЙН НУТГААР ДАМЖИНА

Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Хятадын Тяньжин боомт, Улаанбаатар хот, ОХУ-ын Улан-Удэ хотын чиглэлд туршилтын ачаа тээвэрлэлт амжилттай болсноор ачаа тээвэрлэлтийн хугацаа богиносч, зам дагасан үйлчилгээ зоогийн газар, бензин шатахуун, авто машины засвар үйлчилгээ зэрэг ажлын байр нэмэгдэх олон талын ач холбогдолтой юм.



“МАНДАХ НАРАН-1000 АЙЛЫН ОРОН СУУЦ”-НЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ОРОН СУУЦНЫ ШАВ ТАВИХ ЁСЛОЛ БОЛОО

Аймагын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, иргэдийг хямд өртөг бүхий орон сууцаар хангах зорилтын хүрээнд Дорноговь аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран Сайншанд суманд 266 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлэв. Замын-Үүд суманд 180 айлын орон сууцны барилгын шав тавьж, тэргүүн ээлжинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, олон хүүхэдтэй айл өрхүүд, ахмад настан, малчид, залуу гэр бүлийг хамруулахаар шийдвэрлэлээ.

# ДОРНОГОВИЙН МЭДЭЭ

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА



Үргэлжлэл.  
Түүрүүч нь I нүүрт

Ирэх 2017 он бидний хувьд их бүтээн байгуулалтын жил байх болно” хэмээн итгэлтэйгээр төгс өгүүлж суугаа эрхэм бол Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин юм. Дашрамд сонирхуулахад, Засаг дарга ард иргэдийг хүлээж авдаг тусгайлсан өдрийг бий болгосон ч түүнийгээ зарлаж суржигнэсэнгүй. Хэн ирнэ, түүнийг чөлөөтэй хүлээн авч уулзан тавьсан асуудал, өргөдөл гомдлыг нь өдөрт нь шийдэж өгөх зарчмаар ажиллаж байгаа юм байна. Ер нь л Засаг дарга ард түмэндээ, иргэддээ нээлттэй ажиллахаар шийджээ. Т.Энхтүвшин даргыг болон тамгын газрын ажилтан, албан хаагчдыг зорьж очсон хэн боловч эзгүй байх аваас хаалган дээрх гар утасных нь дугаар руу залган цаг товлож болох аж. Монголын төрд үгүйлэгдээд байгаа энэхүү нээлттэй үйлчилгээг бусад аймгийнхан ч нэвтрүүлээсэй гэж хүсэх байна.

**Та өнөөдөр тун завгүй онжлоо. Иргэдтэйгээ хийсэн уулзалт тань сайхан боллоо. Уулзалтад ирсэн иргэд “Бид их зөв хүнээ гаргаж ирлээ, их ажил амжуулсан байна” хэмээцгээн сэтгэл хангалуун ярьцгаахыг сонсож суулаа. Танд юуны түрүүнд баяр хүргэе.**

Баярлалаа. Цаг хугацаа нисэх мэт хурдан өнгөрчээ. Нэг л мэдсэн ажлаа аваад 100 хоносон байна. Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат 2016 оны дол дугаар сарын 09-ний өдрийн 17:30 цагт Дорноговь аймгийн Засаг даргаар томилогч, батламжлан гарын үсэг зурсан. Улсын их баяр наадмын өдрүүд таарсан учраас 18-ны өдрөөс ажиглаа орсон. Өнөөдөр 2016 оны арваннэгдүгээр сарын 18-ны өдөр. Эргээд харахад дорноговьчууд бид хамтдаа багагүй зүйлийг хийж бүтээжээ. Хийе гэсэн сэтгэл байхад бүтээж болдгийг цонхны цаана сүндэрлэж буй орон сууцны шинэ хорооллын бүтээн байгуулалтаас бид хамтдаа харлаа. 2017 он гаргаад 260 айл шинэ орон сууцандаа гал голомтоо бадраана. Өнөөдөр миний сэтгэл хангалуун, сайхан байна.

**Хоёулаа ярилцлагаа эдийн засгийн ямар чадавхитай аймаг хүлээж авав гэдгээс эхлэх нь зөв болов уу?**

Үнэнийг хэлэхэд маш хурдан 2,8 тэрбум төгрөгийн өртэй аймаг хүлээж авсан. Орлого нь 2,4 тэрбум төгрөгөөр тасарсан байх жишээтэй. Тэр хэрээр ажилгүй

иргэдийн тоо эрс нэмэгдэж, үүнийг дагаад амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой иргэдийн тоо нэмэгдчихэж байгаа юм. Дээр нь төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага гэдэг зүйл үндсэндээ суларч, хэн нь дарга, хэн нь мэргэжилтэн юм бэ гэдэг нь ойлгогдохоо больсон. Ийм аймгийг хүлээж авсан. Гэвч өр ихтэй гээд төрийн ажлыг зогсоож болохгүй биз дээ. Тиймээс ажлаа юун түрүүнд хуримтлагдсан их өрийг барагдуулах арга замыг хайж, эхний ээлжинд татварынхаа бааз суурийг сайжруулах, цаашлаад орлого цуглуулахаас эхэлсэн. Ингэж ажилласны үр дүнд бид тодорхой хэмжээний орлогыг цуглуулж чадсан. Ялангуяа шүүхийн шийдвэр гарчихсан байхад татвараа төлдөггүй аж ахуйн нэгж, байгууллагуудтай нэлээд тулж ажилласан. Заримд нь дансыг нь хаалгүйгээр хугацаа өгч, боломж олгосон. Бас аймгийн эдийн засагт нэмэр тус болохуйц уул уурхай эрхлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийн тулд юун түрүүнд аж ахуйн нэгжүүд тухайн сум, орон нутгийн иргэдийн ажлын байраар хангагдаж байх, замаа засдаг, татвараа цаг хугацаанд нь төлдөг, цаашлаад эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын асуудлыг эхний ээлжинд шийддэг байх зарчмаар хамтран ажиллах гэрээ байгуулаа. Засаг дарга болон түүний Тамгын газрын хувьд ч аж ахуйн нэгж, байгууллагын өмнө хариуцлага хүлээдэг байх ёстой. Уул уурхайн компаниудын дийлэнх нь гадаадын хөрөнгө оруулалттай. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ, хамтарч ажиллана гэж байгаа бол орон нутгийн удирдлагын зүгээс үйл ажиллагааг нь саадгүй явуулах, төрийн хяналт шалгалтын дарамтыг багасгах тухайд санал санаачилгатай ажиллах учиртай. Ийм дэмжлэгийг гадныханд үзүүлж байгаагийн цаад мөн чанар нь миний дээр дурьдсан дөрвөн асуудлыг цаг тухай бүрд нь шийдэх явдал юм. Үүнээс гадна энэ сардаа багтаан орон нутгийн бизнес эрхлэгчид оролцсон форумьг зохион байгуулахаар бэлдэж байна. Бизнес эрхлэгчидтэйгээ хамтран, тэдний дэмжлэгтэйгээр ажилтай, орлоготой иргэнийгээ асуудлыг шийдэх учиртай. Энэхүү форумд хууль хяналтын байгууллага, гааль, хилийн мэргэжлийн хяналтынхан оролцоно.

## ТЭНХТҮВШИН: ДОРНОГОВЬ ХАМААРАХ УЧРААС

Төмөр зам, авто замын аль аль нь байна. Зүүн бүсийн хамгийн том цахилгаан шугам сүлжээ бий. Байнгын ажиллагаатай хоёр боомттой. Барилгын материалын үнэ хямд гээд олон боломжийг нэрлэж болно. Ирэх дөрвөн жилд ажилгүй иргэдийн тоо багасна. Өнгөрсөн намар Өргөн суманд “Монполимет” компанийн цементийн үйлдвэр ашиглалтад орсон. Тэнд 365 ажлын байр шинээр бий болсон. Ирэх дөрөвдүгээр сард “МАК” компанийн Хөх цавын цементийн үйлдвэр ашиглалтад орно. Тэнд 700 ажлын байр шинээр бий болно. Энэ хоёр аж ахуйн нэгж аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөр дамжуулаад боловсон хүчнээ бэлтгэж, Даланжаргалан суманд суурьшлын бүсээ тогтоон ажилчдынхаа байр, орон сууцыг барьж байна. Түүнчлэн 2018 оны дөрөвдүгээр сард Цагаан суваргын орд ашиглалтад орчих юм бол Хатанбулаг, Мандах,

**шиг санагдах юм?**

Тантай санал нэг байна. Хамарын хийдийн Хан Баянзүрх уул, Энергийн төвийг түшиглээд аялал жуулчлалын төв байгуулах боломж бидэнд бий. Мөрийн хөтөлбөртөө ч тусгасан. Зөвхөн дотоодын гэлтгүй ОХУ-ын Улан-Үдэ хотын иргэд аялаад эхэлсэн. БНХАУ-аас манай улсад суугаа Элчин сайдтай уулзаж, визний асуудлаар санал солилцсон. Хятад иргэдэд Эрэн-Замын Үүд-Сайншанд чиглэлийн хоёр хоногийн аяллыг санал болгож болох юм. Тэд Эрэнээс автобусаар хил гарч тэндээсээ рэйлбусаар Хамарын хийд дээр хоёр хоног амрангаа аялж болно шүү дээ. Эрэн хот жилдээ нэг сая нэг зуун мянга гаруй жуулчин хүлээж авч байна. Ядаж тэднээс 150 мянгыг нь бид хүлээгээд авахад л хангалттай бус уу. Үүнээс гадна Ханги мандлын боомтоор уул уурхайн бүтээгдэхүүнийг

онцолж хэлэх нэг зүйл бол Дорноговь аймгийн Замын-Үүд суманд “Шинэ сум” төслийн хүрээнд баригдаж эхлээд хаягдсан барилга хэд хэд бий. Эзэн холбогдогчгүй, мөнгө нь байхгүй барилгуудыг гүйцээх, санхүүжилтийг нь 2017 оны төсөвт суулгах, мөнгийг нь аваад ажлаа гүйцээлгүй орхисон компаниудыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, барилгын ажлыг эхлүүлэх гээд хөөцөлдөх ажил их байна.

**Бүтээн байгуулалтын талаар сонсох сайхан байна. Гэхдээ газар дээрх бүтээн байгуулалт, газар доорх байгуулалттайгаа зохицох ёстой. Энэ газар доорх байгууламж дах чадвар хэр байгаа юм бол?**

Газар доорх бүтээн байгуулалтыг хийх боломжтой. Замын-Үүдийн чөлөөт бүсийн талаар олон ч Засгийн газар ярилса. Улс төрийн тоглолтын мөнхийн сэдэв



**-Аливаа хөгжил төлөвлөгөөгүйгээр явахгүй шүү дээ. Тиймээс надад Дорноговь аймгийн “Хөгжлийн загвар төлөвлөгөө” сонин байна?**

Ажлаа хүлээж аваад удаагүй байхдаа миний эхлүүлсэн ажлуудын нэг нь “Хөгжлийн төлөвлөгөө” үйл ажиллагааны хөтөлбөрөө аймгийн ИТХ-аар батлуулаад амжсан. Төрж өссөн, эдүгээ ажиллаж амьдарч байгаа Дорнын цэнхэр говийн хөгжил цэцэглэлт иргэн бүрийн хичээл зүтгэлээс ихээхэн шалтгаална. Түүнээс дан ганц аймгийн Засаг дарга эсвэл АЗДТГ зүтгээд хөгжихгүй. Хөгжлийн төлөө иргэн нь, төрийн бус байгууллага нь, аж ахуйн нэгжүүд нь хамтдаа хөдөлмөрлөж, сэтгэлээ зориулах аваас амжилтад хүрнэ. Энэ үүднээс “Хөгжлийн төлөө хамтдаа” хөтөлбөрөө боловсруулсан. Эхнээсээ хэрэгжээд эхэлсэн. Тухайлбал, дээр онцгойлон дурьдсан орон сууцны асуудал байна. Мөрийн хөтөлбөрт хямд үнэтэй, чанартай орон сууцар хангана гэдэг заалт буй. Энэ ажлаа УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан болон нутгийн зөвлөлийнхөө дэмжлэгтэй өнгөрсөн наймдугаар сарын 29-нд суурийг нь тавьж эхлүүлсэн. Ирэх оны долдугаар сард ашиглалтад орно. Бид 1000 айлын орон сууц барина гэж төлөвлөсөн. Энэ хүрээнд сүүлийн жилүүдэд хүн амын нягтаршил нь их болоод байгаа Замын-Үүд болоод төмөр зам дагуух сум суурингуудад орон сууцны хорооллуудыг барина. Түүнчлэн Замын-Үүдэд тээвэр ложистикийн төв хэмээх томоохон бүтээн байгуулалтыг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр эхлүүлсэн гэх мэтчилэн хэд хэдэн төслийг нэрлэж болох байна. Та бүхэн санаж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд Дорноговь аймагт ажиллах үеэр Мандах сумын Цагаан суваргын орд, Даланжаргалан суманд дахь “МАК” компанийн Хөх цавын цементийн үйлдвэрийг танилцуулсан. Цагаан суваргын зэс молибдений орд 2018 оны дөрөвдүгээр сард ашиглалтад орно. Энэ бүхний үр дүнд Дорноговь аймагт маш их хэмжээний хөрөнгө оруулалт түүнийг дагаад хөгжил ирэх юм. Ажлын байр ч хэдэн зуугаараа бий болно. Дорноговь бол хурдан хөгжих боломжтой аймаг.

Сайхандулаан сумдад бас л 2000 гаруй ажлын байр бий болох юм. Мөн төмөр зам тавих асуудал яригдаж байгаа. Босоо, хэвтээ чиглэлийн төмөр замын ажил эхлэх юм бол төмөр зам дагасан өртөө зангилаанууд, бүтээн байгуулалтын ажлууд орноно. Энэ бүхэн Дорноговь аймгийн хөгжлийн гарц мөн үү гэвэл мөн.

Нөгөөтэйгүүр, улсын эдийн засаг хүнд байгаа энэ үед аль болох гадаад харилцааг чухалчлах ёстой гэж би хувьдаа үзэж байгаа. Дорноговьчуудын тухайд боломж нь ч байна. Урд хөрштэйгөө бид маш сайн харилцаатай явж ирсэн. Саяхан Замын-Үүд дэх консул, ноён Цай Вань руй бидэнтэй уулзаад бусан. Айлчлалын хүрээнд Дорноговь аймгийн бүх сургууль урд хөршийн хил залгаа мужийнхаа сургууль, цэцэрлэгтэй хамтран ажиллахаар болсон.

Үүнээс гадна АНУ-ын Элчин сайд, хатагтай Женифер Зимдал Галт манай аймагт ажиллах үеэр Замын-Үүд суманд айлчилж, танилцсан. Энэ үеэр цэцэрлэг, сургуулийн барилга барьж өгөхөөр болсон. Ирэх хавраас цэцэрлэгийн барилга эхлэх бол 2018 онд сургуулийн барилгаа эхлүүлнэ.

Японы Шизуоко мужтай хамтран ажиллах гэрээг ирэх арванхоёрдугаар сард үзэгдэнэ. Гэрээний хүрээнд аймгийнхаа их, дээд сургууль төгсөж байгаа оюутнуудыг тэдний зардлаар үргэлжлүүлэн сургахын сацуу хөгжлийн бэрхшээлтэй, амьдралын төвшин доогуур айлын хүүхдийг Японд аялуулах асуудал яригдсан. Түүнчлэн ДЦС-ын инженерүүдийнхээ мэргэжлийг дээшлүүлэхээр болсон. Хамтдаа хөгжье гэж хятадууд ярьдаг. Бид ч үүнийг бодолдож ёстой. Ер нь бол дөрвөн жил богино хугацаа. Бид зүгээр суухгүй. Гадаадын болон дотоодын, орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан хийх ажлууд их байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд ч өөрийн хөрөнгө оруулалтаар хийх ажлуудаа төлөвлөсөн байгаа.

**Дорноговь бол аялал жуулчлал хөгжих хамгийн боломжтой аймаг. Аялал жуулчлалын хамгийн том зах зээл дэргэд тань хил залгаа оршиж буй. Визийн асуудал дээр та бүхэн санаачилга гаргахад л хангалттай юм**

экспортлодог. Бид ойрын үед Ханги мандлын боомтын тосгоны захирагчийн ажлын албыг байгуулахаар төлөвлөж байгаа.

**Та эдийн засагч болохоороо үр дүнгээ урьдчилан харж чадаж байна. Гэхдээ төсөв гэж зүйл бий. Дорноговь аймгийн 2017 оны төсөв өр нь ямархуу байдлаар батлагдав.**

Би дээр өрийн тухай өгүүлсэн. 2,8 тэрбум төгрөгийн өртэй бид юун түрүүнд өрөө барагдуулах ёстой. Нэмж өр тавьж болохгүй. Ирэх оны төсөвт томоохон бүтээн байгуулалттай холбоотой санхүүжилт тусгагдаагүй. Дорноговь өөрийгөө санхүүжүүлдэг аймаг. Тиймээс орлого нэмэгдүүлэх цаашлаад татварын орлогоо цаг хугацаанд нь бүрдүүлэх асуудал чухал. Гэхдээ бидэнд шийдвэл зохих, хөрөнгө гаргах асуудал бий. Дорноговь аймгийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр эхлүүлнэ. Тендерийг нь Барилга, хот байгуулалтын яам зарлана.

Үүнээс гадна цэцэрлэгт хүрээлэн, соёл амралтын хүрээлэнг шинээр байгуулах, аймгийн төвийн замыг асфальтан болгоно гэж бодож байгаа. Манай замыг хүмүүс асфальтан зам гэж хардаг. Тийм биш, Зүүнбаянгийн нефтийн шаарыг элс, хайргатай хольж тавьсан зам. Энэ нь даац муутай. Тиймээс энэ замаа асфальтан хучилттай болгоё гээд байгаа хэрэг. Дээр нь Дорноговь аймгийн төвд 1990 оноос өмнө баригдсан барилгуудыг нэг удаа сайн дулаалж, дэврийг нь засч өгье гэж шийдсэн. Ямар ч байсан бид ирэх жил ногоон хот болно гэсэн зорилт тавьсан. Хатууддаа соёл амралтын хүрээлэн байгуулаа. Замдагасан ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлнэ. Өнөөдөр өглөө Сайншанд сумын Засаг дарга болон холбогдох хэлтсийн дарга нараа дагуулаад аймгийнхаа төвийг тойроод ирлээ. Аймгийнхаа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах талаар санал солилцоо. Түүнчлэн гэрэлтүүлгээ сайжруулах тухайд хөрөнгө гаргах нь зөв гэдэг дээр санал нэгдлээ. Ирэх оны төсөв удахгүй батлагдаана. Түүнийгээ иргэдээрээ хэлэлцүүлнэ. Энд

**болсон энэ зүйлийг арай өөрөөр шийдэх хувилбар байна уу, та бүхэнд?**

Би Сайншандын унаган иргэн. Аж үйлдвэрийн парк байгуулаа гэж хэдэн жил шуу хийсэн. Бүхий л боловсруулах үйлдвэрүүд манай аймагт баригдах юм гэнэ гээд л газар сонгон тууз хайчилж байсныг нь бид мэднэ. Эцсийн дүндээ аж үйлдвэрийн парк байтугай ганц ч барилга, ганц ч үйлдвэр баригдаагүй. Тиймээс би Замын Үүдийн чөлөөт бүс байгуулах тухайд анхаарал хандуулан ажиллаж байна. Чөлөөт бүсийн асуудлаар хоёр ч удаа урд хөршийн холбогдох албаны хүмүүстэй санал солилцоод ирсэн. Гурван улсын эдийн засгийн форум БНХАУ-д зохион байгуулагдсан. Энэ үеэр Замын-Үүдийн чөлөөт бүсийн асуудлыг БНХАУ, ОХУ-ын төлөөлөгчдөд танилцуулахад Замын-Үүдийн чөлөөт бүсийг яаралтай ашиглалтад оруулах, үйл ажиллагааг нь эхлүүлэх талаар ярьсан. Мэдээд чөлөөт бүсэд үндэсний томоохон үйлдвэрүүд баригдах нь гарцаагүй. Гэхдээ миний хувьд эхний ээлжинд үндэсний бүтээгдэхүүнээ дэлгэр худалдаалах 2-3 их дэлгүүрийг барих саналтай байгаа. Үүнийг л эхний ээлжинд эхлүүлчихмээр байна. Дараа нь том том үйлдвэрүүдээ барина биз дээ. Чөлөөт бүс БНХАУ-д бус Монголын талд баригдана шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэдгийг манай урд хөршийнхон байтугай дэлхий мэдэж байгаа шүү дээ. Эрэн хөтөд зохион байгуулагдсан гурван улсын форумын үеэр манай хиам, мах махан бүтээгдэхүүн, ааруул, эзгийг, оёсон дээл хувцас хамгийн түрүүнд зарагдсан. Манайхан Хятад руу тариалсан төмс, хар гуриала зөөгөөд эхэллээ. Тиймээс бид эцэ цэвэр бүтээ

# ДОРНОГОВИЙН МЭДЭЭ

# АЙМГИЙН ХӨГЖИЛ, ДЭВШИЛ БИДНЭЭС УЛСТӨРЖИЖ БОЛОХГҮЙ ШҮҮ ДЭЭ

аймгийг бодвол харьцангуй бага буюу 1.8 сая малтай. Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ чиглэлээр ажиллаж байх.

**-Аймаг бүү хэл улс гүрэн хөгжихөд улстөржилт саад болдог. Дорноговьчуудтаныг улстөржилгүйгээр багаа бүрдүүлсэн хэмээн ам сайтай байна лээ.**

-Бид улстөржиж болохгүй шүү дээ. Дорноговь аймгийг хөгжүүлэхийн төлөө зүтгэе гэж байгаа юм бол наамаар ялгаварлахгүйгээр хамтарч ажиллана гэсэн зарчмыг баримталж байгаа. Дорноговь аймгийн нүүр царай ирэх дөрвөн жилд ямар байх нь биднээс хамаарах учраас бид хөгжил дэвшилд улстөржиж болохгүй. Манай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан ч ингэж зөвлөдөг. Тэрбээр ирэх дөрвөн жилд орон нутагтаа бүтээн байгуулалт өрнүүлэн, гадаад дотоодын төсөл хөтөлбөрийг Дорноговь аймаг руу хэрэгжүүлэх зорилготойгоор ажиллаж байна. Өөрийнхөрөнгө оруулалтаар Дорноговь аймагт маш олон бүтээн байгуулалтыг өрнүүлснийг та бүхэн мэдэж байгаа байх. Аймгийн төвд гэхэд л 150 хүүхдийн цэцэрлэг, сумдад эмнэлэг, төрийн албан хаагчдын орон сууц барьсан. Түүнчлэн 1000 айлын орон сууцны хорооллын барилгын ажлыг эхлүүлсэн. Орон сууцны м2 нь 650 мянган төгрөг гээд төсөөл дөө. Нөгөөтэйгүүр, би ирэх дөрвөн жилд улс төрийн

ямар нэг үйл ажиллагааны дарамт шахалтад орохгүй. Нийт иргэдийнхээ санал, оролцооны үндсэн дээр бүх ажлаа зохион байгуулаад явна. Хэн нэгэн улстөрч, хэн нэгэн намын нөлөөгөөр бидний ажил зогсохгүй. Нэгэнт хийхээр төлөвлөсөн л бол түүнийгээ хийгээд л явна. Миний хувьд өөрөө намын дарга. Тийм учраас энэ ажлыг ямар ч гэсэн Дорноговь аймгийн бүс нутгийн ард иргэдийн дунд явуулсан хэлэлцүүлэг, энэ мэт санаачилгад тулгуурлан бүтээн байгуулалтын ажлыг хийх ёстой гэсэн байр суурийг баримталж ажиллана.

**-Таны ширээн дээрх хавтастай төслүүд түүрхэнэс хойш анхаарал татлаа?**

-Сэтгүүлчид гэж ажигч улс шүү. Миний ширээн дээр дөрвөн янзын төсөл байна. Эхнийх нь Хүүхдийн зуслан. Манай аймаг хүүхдийн зуслангүй. Харамсалтай байгаа биз. Тиймээс ирэх зун үгүй ядаж, нэг хүүхдийн зуслан байгуулчих юмсан гэж бодоод зураг төслийг нь гаргуулсан хэрэг. Үүнийгээ бариад гадаад дотоодын хэд хэдэн хөрөнгө оруулагчидтай уулзлаа. Бүгд л дэмжжэ гэж байна. Хоёр дахь нь зүүн бүсийн халамжийн төв гэж байдаг. Тэнд Говь-Сүмбэр, Өмнөговийн орон гэргүй, үр хүүхэд нь нас барсан, хамаатан садангүй ганц бие хөгшчүүдийг асардаг юм. Тийм 28 хүн бий. Сүүлийн жилүүдэд бусад аймгаас яриад манайд орон

...2017, 2018 он ажил буцалсан, бүтээн байгуулалт өрнөсөн жил байх болно. Би хэлсэндээ хүрдэг, тус тас байхыг л эрхэмлэдэг. Түүнээс биш шийдэх, шийдэхгүй нь ч мэдэхгүй дүлэгнээд байдаг, хов жив ярьж, хэн нэгнийг муулж, далдуур хор найруулдаг хүнд дургүй. Тамгын газрынхандаа ч хэлдэг. Энэ нь болно, энэ нь болохгүй гэдгээ тус тас шийдээд явчихвал нэгдүгээрт өөрт амар, хоёрдугаарт нэг нэгнийхээ үнэтэй цагийг үрээд байхгүй шүү дээ...

гэргүй, асран хамгаалагчгүй иргэдийг аваач гэж хүсэлтийг ирүүлдэг болсон. Гэтэл манай төв ачааллаа даахаа больсон

учир хүн нэмж авах боломжгүй болоод байгаа юм. Тиймээс халамжийн төвөө өргөтгөх төсөл боловсруулсан.

Гурав дахь нь сумдад баригдах спорт заал. Эхний нэг суманд барьж ашиглалтад оруулсан. Иргэд маш их талархаж хүлээж авсан. Сумдын спорт заалны хөрөнгийг шийдсэн. Аймгийн хүн амын тоо нэмэгдэж буйтай холбоотойгоор шинэ спорт цогцолбор барих төлөвлөгөөтэй байна. Манай 1980-аад онд баригдсан хуучин спорт цогцолбор ачааллаа дийлэхээ больсон. Мөн түүнчлэн ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөгжлийн төв байгуулах зорилго тавьсан. Миний хамгийн их санаа зовниж буй асуудал бол энэ. Хөгжлийн төвийг зайлшгүй барих ёстой. Яагаад гэвэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй. Манай УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан 150 хүүхдийн цэцэрлэг барьсан. Тэндээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн анги байгуулсан. Зориулалтын ширээ, тоглоом наадгай, дасгал хийх тоног төхөөрөмж гээд бүрэн тохижуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүд ажил эрхэлдэггүй. Байнга хүүхдээ хараад гэртээ байж байдаг юм. Энэ утгаараа маш ач холбогдол бүхий алхам болсон. Үүнээс гадна цэцэрлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд найман нас хүрээд хаачих вэ

гэдэг нэг асуудал тулгардаг. Эргээд гэртээ очих уу. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийг зайлшгүй барих ёстой.

**-Ингэхэд та хэн бэ. Өөрийнхөө тухай яриач?**

-Би аймгийн төвийн унаган хүүхэд. Эндээ арван жилийн сургууль дүүргэсэн. Мэргэжил маань санхүүч. Өмнө нь Дорноговь аймгийн Санхүүгийн хэлтсийн дарга, АЗДТ-ын даргаар тус тус дөрвөн жил ажилласан. Мөн аймгийнхаа Мэргэжлийн хяналтын газрын даргын албыг долоон жил хашсан. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга, Хан-Уул дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар ажиллаж байлаа. Миний хувьд аймгийн Засаг даргын жаргал, зовлонг сайн мэднэ. Хоёрдугаарт аймгийн Засаг дарга хүн ажлаа юунаас эхлэвэл амжилтад хүрэх вэ гэдгийг аймгийн засаг даргын Тамгын газрын даргын албыг тодорхой хугацаанд хашиж явсан хүний хувьд төсөөлж чадсан. Харин одоо бол хөгжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг зарчмыг л баримтална. Түүрчлэн Засаг даргын хамгийн том алдаа бол Иргэдийн төлөөлөгчдийн хурал дээрээ ороод 31 төлөөлөгчийн гаргасан бүхий л саналыг төсөв дээрээ тавьчихдаг байсан. Бид олж байгаа орлогодоо таарсан зарлагыг гаргах ёстой. Орлого нь бага, зарлага нь их байх юм бол бид алдагдал хүлээнэ. Одоо надад яг ийм байдал

тулгарчихсан. Би ирэх онд 2.8 тэрбум төгрөгийн өртэй орно. Тэгэхээр дараа жилийнхээ орлогоос өрөө төлнө гэсэн үг. Өмнөх Засаг дарга орлого нь орж ирэхгүй гэдгийг мэдсээр байж хэт их ажил төлөвлөсөн. Тэр нь өөрийг нь огцруулна гэх ч юм уу намын хүмүүсийн шантаажаас болдог байсан байх. Хүмүүст таалагдахын тулд хэт их ажил төлөвлөвөл эцэстээ биелэхгүй, биелэх боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Эдүгээ 2017 он гарах гэж байхад 2015, 2016 оны төлөвлөсөн ажил нь биелээгүй л байх жишээтэй. Тухайн оны юм тэр ондоо л биелдэг байх ёстой. Энэ мэт асуудал бий. Ямартай ч, 2017, 2018 он ажил буцалсан, бүтээн байгуулалт өрнөсөн жил байх болно. Би хэлсэндээ хүрдэг, тус тас байхыг л эрхэмлэдэг. Түүнээс биш шийдэх, шийдэхгүй нь ч мэдэхгүй дүлэгнээд байдаг, хов жив ярьж, хэн нэгнийг муулж, далдуур хор найруулдаг хүнд дургүй. Тамгын газрынхандаа ч хэлдэг. Энэ нь болно, энэ нь болохгүй гэдгээ тус тас шийдээд явчихвал нэгдүгээрт өөрт амар, хоёрдугаарт нэг нэгнийхээ үнэтэй цагийг үрээд байхгүй шүү дээ.

**-Цаг гарган бидэнтэй ярилцсан танд баярлалаа. Таны цаашдын их үйлсэд өндөр амжилтыг хүсэн ерөөе.**

-Баярлалаа. Танай сонинь хамт олонд мөн өндөр амжилт хүсье.

## 100 ХОНОГ - ОНЦЛОХ АЖИЛ



**ЗАМЫН-ҮҮД СУМАНД СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ БАРИХААР ШИЙДВЭРЛЭВ**

АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, хатагтай Женифер Зимдал Гаит 2016 оны долдугаар сард Дорноговь аймагт айлчлав. Энэхүү айлчлалын хүрээнд Замын-Үүд суманд хүүхдийн цэцэрлэг, сургуулийн барилга барихаар шийдвэрлэсэн бөгөөд барилгын ажлыг 2017 оны II улиралд эхлүүлэхээр боллоо.



**БҮС НУТГИЙН АЯЛАА ЖУУЛЧЛАЛЫН АЖЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЭХЛЭЛ ТАВИГДАЛАА**

БНХАУ-аас Дорноговь аймгийн Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консул Цай Вэнруй, Эрээн хотын Засаг даргын орлогч н.Саранчимэг тэргүүтэй төлөөлөгчид Дорноговь аймагт ажиллаж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийг өргөжүүлэн хөгжүүлэх, эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарт хамтран ажиллахаар шийдвэрлэв. Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Эрхүү, Улан-Удэ хотоос Хамарын хийд, Ханбаянзүрх уул, Шамбалын орон чиглэлд 2-3 хоногийн хугацаатай жуулчид ирүүлж байхаар харилцан тохиролцлоо.



**ДОРНОГОВЬ АЙМАГ, ШИЗУОКА МУЖИЙН ХАМТЫН АЖИЛААГАНЫ ТАВАН ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭЭ**

Дорноговь аймаг болон Япон улсын Шизуока муж хооронд байгуулсан ах дүүгийн найрамдалт харилцааны таван жилийн ойн баярыг 2016 оны наймдугаар сард тэмдэглэн өнгөрүүлээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд Япон улсын Шизуока мужаас 30 сурагч, таван багш, мужийн дарга тэргүүтэй 20 албаны хүн Дорноговь аймагтай танилцсан. Мөн сурагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд 2016 оны аравдугаар сард 30 сурагч, гурван багш Япон улсын Шизуока мужийн түүх соёл, ёс заншил, бүтээн байгуулалттай танилцаад ирлээ.



**ГУРВАН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ХАМТЫН АЖИЛААГАНЫ УУАЗАЛТАД ОРОЛЦОВ**

БНХАУ, Монгол, ОХУ хоорондын бүс нутгуудын эдийн засаг, худалдааны идэвхтэй харилцан ашигтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор гурван улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны чуулганыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Шилийн, Эрээн хотуудад 2016 оны есдүгээр сард зохион байгуулав. Энэхүү чуулганы гол онцлог нь гурван улсын аж ахуйн нэгжүүдийн худалдааны харилцаа, эрүүл мэнд, аялал жуулчлал болон эдийн засаг, худалдааны харилцааг бэхжүүлэхэд оршино.



**ЗАМЫН-ҮҮДИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭЭ**

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдын ажлын албаны даргаар ахлуулсан ажлын бүрэлдэхүүнийг Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүстэй танилцуулж, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын барилга, байгууламжийн ажлыг 2017 оноос эхлүүлэхээр шийдвэрлэв. Цаашид Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн асуудлыг хариуцсан байнгын ажиллагаатай хамтарсан ажлын хэсэг гаргаж ажиллахаар болов.



**БНХАУ-ААС ЗАМЫН-ҮҮД СУМАНД СУУГАА ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТАРЧ АЖИЛААХААР БОЛОВ**

БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консулын газрын дэд ерөнхий консул, хатагтай Ван Жюнь тэргүүтэй төлөөлөгчид Дорноговь аймагт айлчиллаа. Дорноговь аймаг дахь АШУУИС-д онц дүнтэй суралцаж байгаа 10 оюутныг сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулах, Ерөнхий боловсролын сургуулийн амьдралын боломж тааруу, онц дүнтэй суралцаж буй 10 сурагчид урамшуулал олгохоор харилцан шийдвэрлэв. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Бугат, Ордос хотуудад 16 багш, эмч нарыг туршлага судлуулахаар явуулав.



**ЗАМЫН-ҮҮД СУМАНД ТЭЭВЭР, ЛОЖИСТИКИЙН ТӨВ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭВ**

Өргөн болон нарийн царигийн ачилт буулгалтын 11.6 км орчим төмөр зам, ложистикийн төв рүү орох-гарах хүнд даацын 19 у/м төмөр бетон гүүрэн байгууламж, 1.6 км автозам, 50 тн, 70 тн гүүрэн краан, эрчим хүчний 110 кВт-ын ЦДАШ, 2\*630кВа, 2\*16000кВа цахилгааны дэд өртөөнүүд, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, холбооны сүлжээ бүхий нийт 128 га талбайг хамарсан Ложистикийн төвийг байгуулах ажлыг эхлүүлээ.



**ЗҮҮНБАЯНГААС ХАНГИ ХИЛИЙН БООМТ ХҮРТЭЛ ШИНЭЭР ТӨМӨР ЗАМ БАРИХААР СУДАЛГААНЫ АЖИЛ ЭХЛЭЛЭЭ**

Улаанбаатар Төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэгээс Монгол Улсын Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх, өсөн нэмэгдэж байгаа ачаа тээврийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг үргэлжлүүлэн Ханги мандал хилийн боомт хүртэл шинээр төмөр зам барих урьдчилсан чиглэлийн судалгааны ажлыг эхлүүлээ.



**САЙНШАНД СУМАНД ХИЙГДЭЖ БҮЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛТАЙ ТАНИЛЦЛАА**

Дорноговь аймгийн Засаг дарга Сайншанд сумын хэмжээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтуудтай танилцлаа. Хийгдэж буй ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, цаашид сайжруулах үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өглөө.

# ДОРНОГОВИЙН МЭДЭЭ

## 100 ХОНОГ - ОНЦЛОХ АЖИЛ



**“ӨРГӨН” СУМАНД ШИНЭ ЦЭЦЭРЛЭГ БАРЬЖ, “ЭРДЭНЭ” СУМЫН ЦЭЦЭРЛЭГТ ИХ ЗАСВАР ХИЙЛЭЭ**

“Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Засаг дарга, Япон Улсын Элчин сайдтай гэрээ байгуулан 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн “Өргөн” суманд 100 хүүхдийн цэцэрлэгийг шинээр барьж, “Эрдэнэ” сумын хүүхдийн цэцэрлэгийн их засварын ажлыг 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж ашиглалтад хүлээлгэн өглөө.



**“МАНДАХ”, “ХАТАНБУЛАГ” СУМДЫГ САХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАНА**

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, УИХ-ын гишүүн Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрчим хүчний сайд П.Ганхүү, аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин болон холбогдох албаны хүүүүс Мандах сумын “Цагаан суварга” ордын 220 кВт-ын цахилгаан эрчим хүч татах ажлын үйл ажиллагаатай танилцлаа. Мандах сумын “Цагаан суварга” ордоос Мандах, Хатанбулаг сумдыг 35 кВт-ын цахилгаан, эрчим хүчинд холбохоор болов.



**ДАЛАНЖАРГАЛАН СУМЫГ ТҮШИГЛЭН ҮЙЛДВЭРИЙН ТОСГОН БАЙГУУЛАНА**

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат тэргүүтэй албаны хүүүүс 2016 оны арваннэгдүгээр сарын 07-ны өдөр Даланжаргалан суманд үйл ажиллагаагаа явуулж буй Хөх цавын цемент шохойн үйлдвэртэй танилцлаа. Хөх цавын цемент шохойн үйлдвэрийг 2017 оны эхний улиралд багтаан ашиглалтад оруулахаар боллоо. Тус үйлдвэр ашиглалтад орсноор 900 гаруй ажлын байр шинээр бий болж, орон нутгаас ажиллах хүчний 50 хувийг бүрдүүлнэ. Хөх цавын цемент, шохойн үйлдвэрийн ажилчдын тосгоныг Даланжаргалан суманд байгуулахаар болов.



**ОЮУТНУУДАД СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭЭ**

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой болон өрх толгойлсон, бүтэн болон хагас өнчин, хөгжлийн бэрхшээлтэй айлын нийт 31 оюутанд орон нутгийн төсвөөс сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлээ.



**“ДОРНОГОВЬ ҮЙЛДВЭРЛЭВ” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА, “НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-2016” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ БОЛОВ**

Дорноговь аймгийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, газар тариалан, мал аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг сурталчлах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Дорноговьд үйлдвэрлэв”, “Алтан намар-2016” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд нийт 12 сумын 40 гаруй аж ахуйн нэгж, 100 гаруй иргэн оролцож, өөрсдийн бүтээгдэхүүний дээжээ ард иргэдэд сурталчлан танилцуулав. Энэ үеэр “Мөнх-Ашиг” хоршоо “ШИЛДЭГ ХОРИШОО”-гоор шалгарсан бол “ШИЛДЭГ СУМ”-аар “Эрдэнэ” сум шалгарлаа.



**“ОРОН СУУЦ-ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ, ТАВ ТУХТАЙ АМЬДРАЛЫН БАТАЛГАА” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАА**

Аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ-аас иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд баригдаж буй шинэ орон сууцнуудын чанар, стандарт, ашиглалтын явцад гарч буй асуудлууд түүнийг хэрхэн шийдвэрлэх, иргэдийг эрүүл, аюулгүй тав тухтай орон сууцаар хангахад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар “Орон сууц-Эрүүл, аюулгүй, тав тухтай амьдралын баталгаа” хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



**“ЗАСГИЙН ГАЗРЫН 100 ХОНОГ”-ИЙН ХҮРЭЭНД НЭЭЛТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ**

“ЗАСГИЙН ГАЗРЫН 100 ХОНОГ” өдөрлөгийн хүрээнд аймгийн ЗДТГ, түүний харьяа агентлаг, төсөвт байгууллагууд, сумдын Засаг даргын Тамгын газар нээлттэй хаалганы өдөрлөгийг 2016 оны аравдугаар сарын 04-ний өдөр Сайншанд суманд зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгөөр Засгийн газар шинэчлэн байгуулагдсан 100 хоногийн хугацаанд орон нутагт хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх бодлого зорилтын талаар иргэдэд танилцуулав.



**БАГШ, УРЛАГ, СОЁЛЫН АЖИЛТНУУДЫН ДУНД СПОРТЫН НААДАМ ЗОХИОН БАЙГУУЛАА**

Багш, урлаг, соёлын ажилтнуудын дунд “Спорт 2016” наадмыг есдүгээр сард спортын долоон төрлөөр зохион байгууллаа. Уг спортын наадмыг зохион байгуулахад аймгийн Засаг дарга 4.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд спортын наадмын нээлтэд оролцож нийт баг, тамирчдад хүндэтгэл үзүүлэн амжилт хүслээ.



**ОЛИМПИЙН ХҮРЭЛ МЕДАЛТАНД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ**

Дорноговь аймгийн Нутгийн зөвлөлөөс Улаанбаатар хотод хоёр өрөө шинэ орон сууц, Дорноговь аймгийн ИТХ-ын хурлаас аймгийн “ХҮНДЭТ ИРГЭН”, аймгийн ЗДТГ болон нутгийн ард иргэдээс 30 сая төгрөг, Сайншанд сумын ЗДТГ-аас Тэргүүний ажилтан цол тэмдэг, Монголын Залуучуудын холбооноос “Тамирчны алдар” тэмдэг болон бусад байгууллагын шагналаар шагнав.



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАГДАВ**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/11 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрийг батлууллаа. Хөтөлбөрт сумд, агентлаг, төрийн байгууллага, иргэдээс нийт 460 гаруй санал ирсэн ба иргэдийн саналд үндэслэн дөрвөн үндсэн бодлогын хүрээнд 79 тэргүүлэх зорилт, 388 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



**“ГАЗРЫН ШИМ-ГОВИЙН НОГОО” ТАРИАЛАНЧДЫГ ДЭМЖИХ ҮҮЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАА**

“Газрын шим-говийн ногоо” уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд Сайншанд суманд дөрвөн улирлын нарлаг хүлэмж байгуулах, Алтанширээ сумын “Сайн-Ус” багт газар тариалангийн бүс байгуулах, Артезын усыг түшиглэн 9 гад дуслын услагааны систем бүхий иж бүрэн услагааны барилга байгууламж барьж, аймгийн төвд нэгдсэн зорь байгуулахаар шийдвэрлэлээ.



**ӨМӨЗО-НЫ ОЛОН УЛСЫН МОНГОЛ ЭМНЭЛГИЙН ЭМЧ НАР ДОРНОГОВЬ АЙМАГТ АЖИЛЛАВ**

Дорноговь аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны хамтын ажиллагааны хүрээнд Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн 12 эмч зүрх судас, мэдрэл, дотор, гэмтэл, чих хамар хоолой, нүд, эмэгтэйчүүд зэрэг чиглэлээр 1172 иргэнд үнэ төлбөргүй үзлэг оношилгоо хийж, 307 иргэнд эмчилгээ хийлээ. ӨМӨЗО-ны Олон улсын Монгол эмнэлгээс аймгийн Эрүүл мэндийн газарт 17.0 сая төгрөгийн үнэ бүхий нярайн шарлагын фото аппаратыг бэлэглэв.

Цаашид хоёр орны эмч, эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудыг харилцан солилцож туршлага судлуулах замаар энэхүү арга хэмжээг уламжлал болгох зохион байгуулахаар боллоо.



**ЗУУНЫ МАНЛАЙ БҮЖИГ ДЭГЛЭЭЧ Ц.СЭВЖИДИЙН НЭРЭМЖИТ УРАЛДААН БОЛОО**

Монгол Улсын Төрийн шагналт, Ардын бүжигчин, Урлагийн гавьяат зүтгэлтэн Зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжид агсны 100 жилийн ойн хүрээнд өсвөрийн бүжигчдийн улсын XXIII наадамд 10 аймаг, Улаанбаатар хотын зургаан дүүргийн 240 гаруй өсвөрийн бүжигчид оролцлоо. Энэхүү арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 5.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.



**НЯГТЛАН БОДОГЧДЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛОВ**

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Мэргэжилдээ баярлалаа” аяныг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Энэхүү аяны хүрээнд аймаг орон нутагтаа өөрийн оюун бодлоо дайчлан ажиллаж буй нийт 75 санхүүчид, нягтлан бодогчдыг хамруулсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулав. Орон нутгийн төсвийн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан ил тод, нээлттэй төлөвлөн хуваарилж, салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн зөв зохистой бодлогыг баримтлах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өглөө.



**ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАВ**

Мал аж ахуй болон төв суурин газрын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах аймгийн Засаг даргын 2016 оны 04, 05 дугаар албан даалгавар гаргаж, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг бүрэн хангалаа. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд аймгийн өвс тэжээлийн аюулгүй нөөцийг Сайншанд суманд 7000 боодол, Алтанширээ суманд 5000 боодол, Хөвстөл суманд 3600 боодол, нийт 15600 боодол өвсийг бэлтгэн нөөцлөөд байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сум бүр 1000-2000 боодол өвсийг сумын нөөцдөө бэлтгэв.

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД БҮРТГЭЛТЭЙ 13 МЯНГАН ГАЛТ ЗЭВСЭГ БИЙ

Н.БАТЗАЯА

*“Зэвсэг-2016” үйл ажиллагааны талаар Улаанбаатар хотын цагдаагийн газрын ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч С.Лхагвадоржоос зарим зүйлийг тодрууллаа.*

**“Зэвсэг-2016” үйл ажиллагаа эхэлсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

Жил бүр улсын хэмжээнд галт зэвсгийн нэгдсэн тооллого явуулдаг “Зэвсэг” үйл ажиллагаа энэ сарын 14-нд эхэллээ. Энэхүү нэгдсэн тооллогод галт зэвсэг эзэмшигч иргэд, хуулийн этгээдүүд өөрийн эзэмшилд байгаа галт зэвсгийг цагдаагийн газрын болон харьяа сум, баг хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт авч ирж бүртгүүлэх ёстой байдаг.

**Гэртээ бүртгэлгүй галт зэвсэг хадгалах тохиолдол байдаг. Тэр дундаа хөдөө орон нутагт их шүү дээ. Энэ тал дээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ?**

Энэ арга хэмжээний нэг онцлог нь гэвэл бүртгэлгүй галт зэвсгийг бүртгүүлэх юм. Өөрөөр хэлбэл, бүртгэлгүй болон гэрчилгээгүй нуугдмал галт зэвсгийг энэхүү арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллага бүртгэлжүүлдэг. Хэрэв “Зэвсэг-2016” үйл ажиллагааны үеэр бүртгэлгүй зэвсэг хадгалж байсан иргэд галт зэвсгээ бүртгүүлэхээр ирсэн тохиолдолд ямар нэгэн захиргааны арга хэмжээ, торгууль, шийтгэл, хураах барих зүйлгүйгээр хууль ёсны дагуу бүртгээд гэрчилгээг нь олгодог байгаа.

**Эзэмшигчээс эзэмшигчид шилжүүлдэг. Энэ**

**тохиолдолд яах вэ?**

Энэ бол шинэ хуулийн дагуу явна. Галт зэвсгийн тухай хууль шинэчлэн батлагдсан байгаа. Тус хуульд хэд хэдэн зүйл шинээр орсон. Тухайлбал, насны хязгаар заасан. Мөн галт зэвсгийн сургалтад суух болсон. Иргэд галт зэвсэг эзэмшиж ашиглах болон аюулгүй ажиллагааны гэсэн хоёр янзын сургалтад суух ёстой. Энэ сургалтад суусан иргэд галт зэвсэг бусдаасаа эзэмшиж, шилжүүлж авах, гадаад улсаас импортлоор оруулж ирэх боломжтой.

**Бүртгүүлдэхээ хаана хандах вэ. Шаардлагатай бичиг баримт бий юу?**

Иргэд Зэвсэг-2016 үйл ажиллагааны хүрээнд өөрсдийн гар дээрх бүртгэлтэй галт зэвсэг болон адилтгах хэрэгслийг бүртгүүлэх ёстой. Бүртгүүлдэхээ журмын дагуу галт зэвсгийн гэрчилгээ, иргэний үнэмлэхний хуулбарыг авч ирнэ. Мөн албан байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээ болон галт зэвсгээ биет байдлаар авч ирж бүртгүүлдэг байгаа.

**Ер нь улсын хэмжээнд бүртгэлтэй хэчнээн галт зэвсэг байдаг вэ?**

Улсын хэмжээн дэх нарийн тоог мэдэхгүй байна. Би нийслэлийн галт зэвсгийн бүртгэл хариуцсан. Нийслэлийн хэмжээнд нийт 13 мянган галт зэвсэг бүртгэлтэй байдаг. Ер нь энэ үйл ажиллагааны гол зорилго нь улсын хэмжээнд байгаа галт зэвсгийн тоог гаргах, галт зэвсгийг бүртгэх, хэрэв иргэн бүртгүүлээгүй нуугдмал галт зэвсэг хадгалж байвал түүнийг бүртгэх юм.

**Хэдэн хүртэл үргэлжлэх вэ?**

Энэхүү үйл ажиллагаа маань энэ сарын 14-нд эхэлсэн байгаа. Нийт 36 хоногийн хугацаанд зохион байгуулагдах юм. Тэгэхээр ирэх сарын 20 хүртэл үргэлжилнэ. Энэ хугацаанд иргэд өөрсдийн гар дээр байгаа галт зэвсгээ бүртгүүлэх боломжтой. Хэрэв зэвсгээ бүртгүүлээгүй бол тэрийгээ яаралтай авч ирж бүртгүүлэх хэрэгтэй. Үйл ажиллагааныхаа хүрээнд ямар нэгэн захиргааны хариуцлага тооцохгүй гэсэн байгаа.



СЭЛЭНГЭ АЙМАГ

### Шаамар суманд “Зөгийн зоорь” барина

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлагийн /ТИКА/ Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулалтын газар хооронд “Зөгийн зоорь барих” тухай төслийн хэлэлцээр байгууллаа. Энэхүү хэлэлцээрт Засаг дарга Ш.Оргил, ТИКА-гийн Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулалтын газрын дэд зохицуулагч Өмөр Гүндюду нар гарын үсэг зурсан юм. Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил үүрэгт ажлаа хүлээн аваад гурван сар гаруйн хугацаа өнгөрч байгаа юм. Үүрэгт ажлаа авсны дараахан Туркийн элчин сайдтай хамтарч ажиллах олон ажлууд дээр санал солилцсоны нэг нь зөгийн зоорь барих түүнчлэн дагалдах бүтээгдэхүүнээ гадаадын зах зээлд гаргах асуудлууд байсан юм. Тэгвэл гурван сарын өмнөх хэлэлцээр ийнхүү биелэлээ олж ажил болон хэрэгжиж эхэлж байгаад Сэлэнгэгчүүд тэр дундаа Шаамрын зөгийчид баяртай хүлээн авч байна. Өнөөдөр Шаамар суманд зөгийн аж ахуй эрхэлж байгаа 10 гаруй аж ахуйн нэгжид 3500 гаруй бүл зөгий нутагшиж байна. Мөн Шаамар сумын зөгийчид жилдээ 60-70 тн зөгийн бал үйлдвэрлэж зах зээлд нийлүүлдэг ажээ.



СЭРЭМЖЛҮҮЛЭГ


### ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЗАМД ЗОРЧИХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛЛАА

Онцгой байдлын ерөнхий газраас өчигдрийн шуурхай албаны мэдээг нэгтгэн гаргаад байна. Ихэнх нутгаар цас орсны улмаас зам, даваа хаагдах болсон. Үүний улмаас орон нутгийн замд зорчих буй иргэд цасанд боогдсон байна. Тодруулбал, Ховд аймгийн

Цэцэг сумын Баян-Овоо багийн нутаг Цагаан-Эрэг гэдэг газарт хувиараа чулуу олборлож байсан 60 хүн, 12 автомашин шатахуун дуусч, Богосын даваанд цасанд боогджээ. Дуудлагын дагуу тус аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчид Цэцэг сум дахь “МОН-ЭНКО”

ХХК-ийн 10 хүн, хоёр автомашин, Мөст сумаас долоон хүн, хоёр автомашин, нийт нийт автомашинтайгаар ажилласан байна. Тиймээс онцын шаардлагагүй тохиолдолд хөдөө орон нутагт зорчихгүй байхыг Онцгой байдлын ерөнхий газраас анхаарууллаа.

PHOTO NEWS



*Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ой тохиож буй энэ өдрүүдэд түүний альдрал, уран бүтээлийг нэгтгэн харуулсан үзэсгэлэнг анх удаа олны хүртээл болгож байна. Энэ хүрээнд Монголын үндэсний түүхийн музейд өнгөрсөн баасан гарагт нэгэн үзэсгэлэн нээлтээ хийлээ. Уг үзэсгэлэнд Монголын зохиолчдын эвлэлийн хороонд хадгалагдаж байсан Д.Нацагдоржийн гэр музейн эд өлгөөс сонирхуулахаас гадна Архивийн ерөнхий газар, Хэл шинжлэлийн хүрээлэн, Түүхийн ухааны хүрээлэнгийн архивын материалуудыг дэлгэжээ.*



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

### Улсын онцгой комисс орон нутагт ажиллаж байна

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга У.Хүрэлсүхийн 21 аймгийн өвөлжилтийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах үүрэг даалгаврыг аймгуудын Онцгой комисст өгсөн билээ. Энэ дагуу зарим тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх эрх бүхий УОК-ын Шуурхай бүлэг энэ сарын 15-ны өдрөөс орон нутагт ажиллаж байна. Баруун болон төвийн бүсийн 13 аймагт Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа М.Энх-Амар, зүүн болон говийн бүсийн найман аймагт Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, хурандаа Б.Ууганбаяраар ахлуулсан шуурхай бүлгүүд

ажиллаж байгаа ажээ. Өнгөрсөн бямба гарагт гэхэд улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа М.Энх-Амарар ахлуулсан ажлын хэсгийнхэн бямба гарагт Сүхбаатар, Дорнод аймагт ажиллаж, аймгийн онцгой комиссын өргөтгөсөн хурлаар хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, цахилгаан эрчим хүч, зам арчлалт, төв суурин газрын бэлэн байдлыг хэлэлцүүлж, Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнтэй уулзалт хийж, улсын нөөцийн салбартай танилцан, Баян-Уул, Цагаан-Овоо сумдад ажиллаж, аймгийн Засаг даргад нөхцөл байдалтай холбогдуулан 18 заалт бүхий зөвлөмж өгчээ. Мөн хурандаа Б.Ууганбаяраар ахлуулсан шуурхай бүлэг

Ховд аймгийн Алтай, Уенч, Булган сумд ажиллажээ. Дээрх сумдад 11 дүгээр сарын 9-ний өдрөөс хойш цас үргэлжлэн орсны улмаас өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, мал бэлчээрт гарахад бэрхшээлтэй болжээ. Цасны зузаан тал газраа 25-35 см, гуу жалга, уулархаг болон хунгарласан газраа 50-70 см байна. Ховд аймгийн Цэцэг, Мөст сумын заагт орших 50 км гаруй үргэлжилсэн Барлагийн давааг нээхээр 11 дүгээр сарын 18-ны өдрөөс “Алтайн зам” ХХК-ийн 11 ажилтан ковч, цас зөөх “Хова” маркийн ачааны машин, автогрейдер зэрэг нийт 3 техник хэрэгсэлтэйгээр хоёр дахь өдрөө ажиллаж давааг нээлээ.

### Онцгойгийнхон долоон настай хүүг аварчээ

Нийслэлийн Баянгол дүүргийн IV дүгээр хороонд айлын цонхоор хүүхэд унах гэж байна гэсэн дуудлага өнгөрсөн бямба гарагт 18:40 цагт иржээ. Дуудлагын дагуу Нийслэлийн аврах ангийн зургаан албан хаагч, хоёр техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, долоон настай М цонхны тавцан

дээр гарсан байсныг гуравдугаар давхраас аврах олсоор бууж, цонхоор оруулж аюулгүй болгон ар гэрийн хүнд хүлээлгэн өгсөн байна. Мөн Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Хараа багийн Найрамдал гэдэг газар иргэн А-ын “Санато” загварын автомашин усанд цөмөрсөн гэсэн дуудлага өчигдөр

аймгийн Онцгой байдлын газарт иржээ. Дуудлагын дагуу тус аймгийн Баянгол сумын Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр ангийн гурван албан хаагч, нэг техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, А, Г, Б нарын гурван иргэнийг татан гаргаж, аюулгүй болгосон байна.



## ФОТО СУРВАЛЖЛАГА

## Далай лам монголчуудад сургаалийг айлчлав



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам манай улсад ес дэх удаагаа айлчиллаа. Тэрбээр айлчлалынхаа хүрээнд Монголын сүсэгтэн олонд зориулж ховор ном айлдсан. Тодруулбал, Богд ламын ван авшиг, Шар жигжид бурхны насны авшиг зэрэг нэн ховор нарийн номын айлтгалыг “Буянт-Ухаа” цогцолборт айлдав. Энэхүү ном нь нас уртасгах, буян хишиг арвижуулах, өлзий хутгийн цог бадрах, санасан хэрэг сэтгэлчлэн бүтэх, барцадыг арилгах, саад зэтгэрийг зайлуулдаг ажээ. Тэрбээр “Эрт үеэс Монголын ард түмэнтэй номын барилдлагатай явж ирсэн. Та бүхний сүсэг бишрэл баттай, үнэнч байгаа нь гайхамшигтай. Би өндөр хөгжилтэй олон оронд очсон. Хөгжил хүний таван мэдрэхүйг амгалан байлгадаг ч дотоод сэтгэлийг амгалан байлгаж чаддаггүй. Дотоод сэтгэл амгалан байх нь бүх зүйлд тустай” хэмээн айлдав. Далай багшийн айлчлал ирэх лхагва гараг хүртэл үргэлжлэх бөгөөд хөтөлбөрт өөрчлөлт орж болзошгүй хэмээн Гандантэгчинлэн хийдээс мэдээлсэн. Дашрамд дурдахад, Дээрхийн гэгээнтэн IV дүгээр Далай лам эдүгэ 81 насныг зооглож буй юм.

